



*Монгол Банк*



**МОНГОЛБАНК**

**ИНФЛЯЦЫН ТАЙЛАН**

**2021**

**3-Р САР**

## АГУУЛГА

|                                                                             |    |
|-----------------------------------------------------------------------------|----|
| МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ .....                                            | 3  |
| МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР .....                                             | 3  |
| I. ИНФЛЯЦ .....                                                             | 6  |
| Инфляцын цаашдын төлөв .....                                                | 7  |
| II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ .....                                               | 9  |
| Потенциал үйлдвэрлэл .....                                                  | 11 |
| Үйлдвэрлэлийн зөрүү .....                                                   | 11 |
| Эдийн засгийн цаашдын төлөв .....                                           | 12 |
| III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН .....                                       | 14 |
| III.1. Хөдөлмөрийн зах зээл .....                                           | 14 |
| III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл .....                                      | 14 |
| III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд .....                                    | 17 |
| III.2.2 Хүү .....                                                           | 19 |
| III.2.3 Валютын ханш .....                                                  | 20 |
| III.2.4 Хөрөнгийн зах зээл .....                                            | 22 |
| III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр .....                           | 24 |
| IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН .....                                        | 26 |
| IV.1 Гадаад эдийн засгийн орчны талаарх төсөөлөлд ашигласан таамаглал ..... | 26 |
| IV.2 Түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ .....                             | 29 |
| IV.3 Төлбөрийн тэнцэл .....                                                 | 31 |

## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцлийг бүрдүүлэх төдийгүй урт хугацаанд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн **инфляцыг 2021-2023 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшинг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсхүл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдахад чиглэсэн арга хэмжээг бодлогын хүүтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк зах зээлийн итгэлийг олж, хүлээлтийг удирдах замаар мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй нээлттэй харилцахад ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ ба зардлын хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтийн хүртээл болгож байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, мөнгөний бодлогын шийдвэр гаргагчдын зорилтыг олон нийтэд ийнхүү нээлттэй танилцуулснаар Монголбанкны бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанкинд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2021 оны 3-р сарын 24-ний өдрийн ээлжит хурлаар:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. Урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 2-р улиралд 350 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргалаа. Уг санхүүжилтийг боловсруулах, үйлчилгээ болон 200 дээш ажиллагчидтай худалдааны салбарын аж, ахуйн нэгжүүдийг хамруулахаар өргөтгөв.

Мөнгөний бодлогын 2021 оны 3-р сарын 24-ны мэдэгдлийг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр татаж авна уу.

## ТОЙМ

Гадаад эдийн засгийн орчин сайжирч, Засгийн газар, Төв банкнаас эрэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж байгаа хэдий ч дотоод эдийн засаг 2021 онд алгуур сэргэх хүлээлт хэвээр байна. Инфляцыг бууруулах чиглэлд нөлөөлж буй нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө арилах, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн төсөөлөл өссөн зэргээс инфляц цаашид нэмэгдэхээр байна.

**Инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөө ирэх саруудад нэмэгдэхээр байна.** 2021 оны 2 дугаар сард инфляц улсын хэмжээнд 2.6 хувь, Улаанбаатар хотод 2.0 хувьд хүрэв. Махны үнэ 2-р сард улирлын хандлагаасаа давж өссөн ч сайжруулсан түлшний үнийг 75 хувь хөнгөлсөн нөлөөгөөр нийлүүлэлтийн шалтгаантай инфляц 1-р улирлыг дуустал бага байх төлөвтэй. Харин 2-р улирлаас нийлүүлэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэхэд; 1) инфляцыг 1 нэгж орчим хувиар бууруулж байгаа шатахууны үнийн суурь үеийн нөлөө арилах, 2) сайжруулсан түлшийг хөнгөлөлттэй үнээр худалдаалах Засгийн газрын шийдвэрийн хэрэгжих хугацаа 4-р сарын 1-ний өдрөөр дуусгавар болох зэрэг нь голлон нөлөөлөхөөр байна. Эрэлтийн хүчин зүйлсийн хувьд инфляцад үзүүлэх нөлөө нь эдийн засгийн идэвхжлийг даган аажмаар нэмэгдэх хандлагатай байна. Цаашид нийлүүлэлтийн шалтгаантай үнийн огцом хэлбэлзэл үүсэхгүй гэж үзвэл 2021 онд инфляц төв банкны зорилтот түвшний интервалд ( $6\% \pm 2\%$ ) хадгалагдах хүлээлттэй байна.

**КОВИД-19 цар тахал дотоодод тархсан нь эдийн засгийн сэргэлтийг удаашруулж, 2021 оны эхний хагаст уул уурхайн бус салбарын идэвхжил төдийлөн нэмэгдэхээргүй байна.** Эдийн засгийн өсөлт 2020 онд төсөөллийн орчимд байлаа. 2021 онд эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнээр уул уурхайн салбар эрчимжих бол цар тахлын сөрөг нөлөө уул уурхайн бус салбарт хүлээлтээс өндөр байна. Улаанбаатар хотод вирусын тархалт нэмэгдэж 2021 оны 2-р сарын 11-ний өдрөөс 23-ны өдрийн хооронд бүх нийтийн бэлэн байдалд шилжин, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон нь 1-р улирлын уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулах нөлөөтэй. Түүнчлэн, КОВИД-19-ийг бүрэн хяналтад оруулах хугацаа удааширч, тархах хүрээ нь тэлж байгаа тул энэ оны 2-р улиралд уул уурхайн бус салбар хэвийн түвшинд хүрч сэргэхээргүй байна. Уул уурхайн салбарын хувьд хилийн бүс нутгуудад халдвар тархахгүй, экспорт хэвийн явагдах тохиолдолд тус салбар 2021 онд өндөр өсөлттэй байх төлөвтэй. Эдийн засгийн цаашдын төлөв хэрхэн өөрчлөгдөх нь дотоодод тархсан КОВИД-19 вирусыг хяналтдаа оруулах хугацаанаас голлон хамаарч байна.

**Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2020 оны 2 дугаар улирлаас алгуур нэмэгдэж, энэ оны 1-р сард 18 хувьд хүрлээ.** Өмнөх онд төсвийн алдагдал тэлж, шаардлагатай санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн идэвхжил сул, зах зээлийн эрсдэл өндөр байсан нь банкны системийн зээлийн өсөлтийг хязгаарлаж, зээлийн өсөлт 2020 оны турш нам түвшинд хадгалагдлаа. Харин ирэх улирлуудад эдийн засгийн сэргэлтийг даган зээлийн өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна.

**Дэлхий нийтээр цар тахлын эсрэг вакцинжуулалт эхэлж, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байна.** Томоохон эдийн засагтай орнуудын 2020 оны 4-р улирлын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарсны дээр БНХАУ, АНУ-ын 2021 оны өсөлтийн төсөөлөл нэмэгдлээ. Хэдийгээр гадаад орчинд цар тахлын шинэ давалгаанууд үүсч дэлхийн эдийн засгийн

идэвхжилд сөргөөр нөлөөлж байгаа боловч тархалтыг хяналтад оруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ эдийн засгийн сэргэлтийн хүлээлт харьцангуй өөдрөг хэвээр байна. Цаашид КОВИД-19 вирусын эсрэг вакцины хүрэлцээ, үйлдвэрлэлийн чадамж, вакцинжуулах хурд зэргээс гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байна.

**Төлбөрийн тэнцэл 2020 оны 4 дүгээр улиралд 1,259 сая ам.доллар буюу ДНБ<sup>1</sup>-ий 9.6 хувьтай тэнцэх ашигтай гарлаа.** Энэ нь өмнөх оны мөн үеэс 1071 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болж, улмаар жилийн дүнгээр төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай байв. Тодруулбал, 2020 оны 4-р улиралд экспорт сэргэж, импорт агшиж, орлогын дансны алдагдал буурснаар урсгал тэнцэл 165.4 сая ам.долларын ашигтай гарсны дээр гадаад зээлийн ашиглалт нэмэгдэж, ГШХО-аас бусад хөрөнгө оруулалтын орох урсгал өссөн нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлжээ. Энэ онд түүхий эдийн үнэ өндөр байгаа нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөөтэй ч дотоодод вирус тархсан нь улс хоорондын ачаа тээврийг хязгаарлаж, улмаар экспорт удаашрах эрсдэлийг үүсгэж байна.

Гадаад худалдааны нөхцөл 2021 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар сайжирлаа. Экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар нэмэгдсэн бол импортын үнэ 3.1 хувиар буурчээ. Гадаад худалдааны нөхцөлийн төсөөлөл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжирсан бөгөөд үүнд зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

---

<sup>1</sup> 4-н улирлын өссөн нэмэгдсэн ДНБ-ий дүн.

## 1. ИНФЛЯЦ

Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2021-2023 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилтыг хэрэгжүүлж эхэлж байна.

### Инфляцын динамик

2020 оны 4 дүгээр улиралд халдвар хамгааллын дэглэм чангарч эрэлтийн саарсантай холбоотойгоор үнийн өсөлт саарахын зэрэгцээ нийлүүлэлтийн хүчин зүйлийн хөдөлгөөн мөн адил буурах чиглэлд хөтөллөө (Зураг I.2). 2020 оны эцэст улсын хэмжээнд жилийн 2.3 хувь, Улаанбаатарт 1.9 хувь байсан инфляц 2021 оны 2 дугаар сард харгалзан 2.6 хувь, 2.0 хувь байна (Зураг I.1).

Зураг I.1

Инфляц



Эх сурвалж: УСХ


Тайлант улиралд өрхийн хэрэглээ болон хөрөнгө оруулалт хумигдан, зээлийн өсөлт саарсан тул үнэ өсөх эрэлтийн дарамт бага хэвээр байв. КОВИД-19-ийн сөрөг нөлөөг зөөллөх бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж буй ч эдийн засагт цар тахлын сөрөг нөлөө уул уурхайн бус салбарт хүлээлтээс өндөр байв. Тухайлбал, дотоодод тархсан халдварын голомтуудыг хумих зорилгоор 11 дүгээр сард бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн нь хэрэглээ, үйлдвэрлэлд хязгаарлалт үүсгэлээ. Хөл хорионы үед

зарим салбаруудын үйл ажиллагаа зогсонги байдалд орон, өрхийн орлого буурах нөхцөл үүсч эрэлтийн шалтгаантай инфляц саарав.

Нэг удаагийн болон нийлүүлэлтийн шалтгаанаар хатуу түлш, шатахуун зэрэг бүтээгдэхүүний үнэ буурсан нь инфляц нам түвшинд байхад нөлөөлж байна (Зураг I.2, Зураг I.3).

Зураг I.2

Ерөнхий инфляц болон нийлүүлэлтийн шинжтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Инфляцын хөдөлгөөнд гол нөлөө үзүүлж буй бүтээгдэхүүнүүд:


- **Махны үнэ** улирлын хандлагаасаа өндөр өсч 2 дугаар сард инфляцын 0.9 нэгж хувийг бүрдүүлэв (Зураг I.3).
- **Шатахууны үнэ** инфляцыг -1.0 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүллээ. Дэлхийн зах зээлд газрын тосны үнэ өсч буйтай холбоотой хилийн үнэ нэмэгдэж байна. Үүнтэй уялдан тайлант сард дизель түлшний үнэ 80 орчим төгрөгөөр өсч, дотоодын шатахууны үнийн инфляцыг бууруулах нөлөө саарч эхэллээ (Зураг I.3).
- **Хатуу түлшний үнэ** буурсан нь инфляцыг -1.3 нэгж хувиар бууруулах нөлөөг үзүүллээ. Засгийн газраас цар тахлын үед иргэдийг дэмжих зорилгоор сайжруулсан түлшний үнийг 75 хувиар

хөнгөлөх шийдвэр гаргаснаар (Засгийн газрын шийдвэр 2021 оны 4 дүгээр сарын 1-ийг хүртэл хэрэгжинэ) сайжруулсан түлшний үнэ хямдарсан нь инфляц бага түвшинд байхад өндөр нөлөө үзүүлж байна (Зураг I.3).

- Уламжлалт сар шинийн баярын үеэр халдвар хамгааллын дэглэмийг чангатгаснаар дотоод эрэлт сул хэвээр байж эрэлтийн шалтгаантай үнийн өсөлт үргэлжлэн саарав.

Зураг I.3

Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: УСХ, Монголбанк

### Төсөөллийн зөрүү

Дөрөвдүгээр улирлын дундаж инфляц 2.9 хувь болсон нь төсөөллөөс 0.3 нэгж хувиар доогуур байв.

Засгийн газраас сайжруулсан түлшний үнийг 50 хувиар хөнгөлөх өмнөх шийдвэр 12 сарын 14-нд 75 хувь болж шинэчлэгдсэн нь төсөөллийн зөрүүний 0.2 нэгж хувийг тайлбарлаж байна. Хүнсний бүтээгдэхүүний үнэ төсөөлөлтэй нийцтэй буюу жилийн 6.8 хувиар өслөө. Харин хүнсний бус бүлгийн үнийн өсөлт, тэр дундаа импортын барааны бүлгийн үнэ жилийн 5.5 хувиар өссөн нь төсөөллөөс бага байв.

## Хүснэгт I.1 Инфляцын төлөвт гарсан өөрчлөлт

| Инфляцын богино хугацааны төсөөллийн таамаглал                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                 |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Өмнөх төсөөлөл 2020Q4-2021Q3                                                                                                                                                                                                         | Одоогийн төсөөлөл 2021Q1-2021Q4                                                                                                                                                                                 |
| <b>Махны үнэ</b>                                                                                                                                                                                                                     | <b>Төсөөлөл нэмэгдсэн</b>                                                                                                                                                                                       |
| Махны үнэ III улиралд төсөөллөөс давж хямдарсан хэдий ч 11-р сараас үнэ нь өсч байгаагаас төсөөллийг нэмэгдүүлэв.                                                                                                                    | Махны үнэ IV улиралд төсөөлөлтэй нийцтэй өссөн хэдий ч 2-р сард улирлын хандлагаасаа өндөр өссөн тул төсөөллийг өмнөх улирлаас бага зэрэг нэмэгдүүлэв.                                                          |
| <b>Импортын барааны үнэ</b>                                                                                                                                                                                                          | <b>Төсөөлөл буурсан</b>                                                                                                                                                                                         |
| Импортын барааны үнийн төсөөлөл III улиралд нийцтэй байсан бол төгрөгийн ханш тогтвортой байж, хөл хориотой холбоотой худалдан авалтын хязгаарлалт үүсч байгаагаас цаашдын төсөөллийг буурууллаа.                                    | Төгрөгийн ханш тогтвортой байж, хөл хориотой холбоотой эдийн засгийн төлөв төсөөллөөс сул байсантай холбоотой импортын барааны үнэ IV улирал, 1-р сард төсөөллөөс багаар өссөн учраас цаашдын төсөөлөл саарлаа. |
| <b>Дотоодын барааны үнэ</b>                                                                                                                                                                                                          | <b>Төсөөлөл хэвэндээ</b>                                                                                                                                                                                        |
| Дотоодын барааны үнийн төсөөлөл III улиралд нийцтэй байсан бол дотоод халдвар гарсантай холбоотой Засгийн газраас авч буй арга хэмжээнд сайжруулсан түлшний үнийг 75%-аар хямдруулан худалдаалах шийдвэр гарсныг төсөөлөлд тусгалаа. | Дотоодын барааны үнийн төсөөлөл IV улиралд нийцтэй байсан бөгөөд төсөөлөл өөрчлөгдөөгүй. Сайжруулсан түлшний үнийг 75%-аар хөнгөлөх Засгийн газрын шийдвэр 4-р сарын 1-ийг хүртэл үргэлжлэхээр байна.           |
| <b>Төрийн зохицуулалттай үнэ</b>                                                                                                                                                                                                     | <b>Төсөөлөл хэвэндээ</b>                                                                                                                                                                                        |
| Төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.                                                                                                                                                                            | Төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.                                                                                                                                                       |
| <b>Шатахууны үнэ</b>                                                                                                                                                                                                                 | <b>Төсөөлөл нэмэгдсэн</b>                                                                                                                                                                                       |
| Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой, гадаад зах зээл дэх газрын тосны үнийн төсөөлөл бага зэрэг саарсанаар төсөөллийг буурууллаа.                                                                                                   | Гадаад зах зээл дэх газрын тосны үнийн төсөөлөл өмнөх улирлаас нэмэгдсэнээр шатахууны үнэ өсөх гадаад эрсдэл нэмэгдлээ.                                                                                         |


Эх сурвалж: Монголбанк

## Инфляцын цаашдын төлөв

Ирэх улирлуудад нийлүүлэлтийн шинжтэй инфляц нэмэгдэх төсөөлөлтэй байна. Тодруулбал, энэ оны 2-р улирлаас инфляцыг 1 нэгж орчим хувиар бууруулж байгаа шатахууны үнийн суурь үеийн нөлөө арилах, 2) сайжруулсан түлшийг хөнгөлөлттэй үнээр худалдаалах<sup>2</sup> Засгийн газрын шийдвэрийн хэрэгжих хугацаа 4-р сарын 1-ний өдрөөр дуусгавар болох зэрэг нь голлон нөлөөлөхөөр байна. Мөн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлтийг даган дотоодын шатахууны үнэ өсөхөөр байна.

Зураг I.4

### Инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

<sup>2</sup> Инфляцыг 2.1 нэгж хувиар бууруулах нөлөөтэй.

Цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлд Засгийн газар болон Төв банкнаас эрэлтийг дэмжих бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ хөл хорионы дэглэм суларч, вакцинжуулалт эхэлсэн нь эдийн засгийн идэвхжлийг эрчимжүүлж, эрэлтийн шинжтэй инфляцыг алгуур өсгөх төлөвтэй. Ирэх онд дотоод эрэлт сэргэж, инфляц Төв банкны зорилтот түвшинд хүрч тогтворжих хүлээлттэй байна.

### Хүснэгт I.2

#### Инфляцын төсөөлөл<sup>3</sup>

|                          | 2020  | 2021*            | 2022*            |
|--------------------------|-------|------------------|------------------|
|                          | гүйц. | төсөөлөл         |                  |
| Инфляц, ХҮИ <sup>4</sup> | 2.9   | 7.2<br>[5.5-9.0] | 5.8<br>[4.3-7.3] |

Эх сурвалж: Монголбанк

### Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал

| Эрсдэл, тодорхой бус байдал                                                                                                                                                                                                                                                                                     | Магадлал  | Нөлөө                |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|----------------------|
| Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдол эсвэл илүүдэл үүсвэл төсөөллийг өөрчлөх эрсдэлтэй. Тухайлбал, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан мах, хүнсний ногооны үнэ огцом хэлбэлзэх, төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ төсөөллөөс давж нэмэгдэх зэрэг нь инфляцын төсөөллийг өөрчлөх шалтгаан болно. | Бага      | Өндөр<br>(өсгөх)     |
| КОВИД-19 цар тахлын дотоод дахь тархалт эрчимжиж, улмаар дахин хорио цээрийн дэглэм тогтоох, хугацааг сунгах тохиолдолд эдийн засгийн идэвхжлийг сулруулж, инфляцыг бууруулах нөлөөтэй.                                                                                                                         | Дунд      | Дунд<br>(бууруу-лах) |
| Нөгөө талаас хөл хорио чангарах тохиолдолд хүнсний зарим бүтээгдэхүүний нөөцийн хомсдол үүсч, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт бий болж болзошгүй.                                                                                                                                                         | Бага      | Бага<br>(өсгөх)      |
| Цар тахлын тархалт эрчимжиж гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэх тохиолдолд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, улмаар төгрөгийн ханшид ирэх дарамт нь инфляцыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.                                                           | Бага-Дунд | Дунд<br>(өсгөх)      |
| Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх арга хэмжээний үр нөлөө хүлээлтээс өндөр байх, Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон төслүүд зэргээс инфляцын төсөөлөл өөрчлөгдөнө.                                                                                                           | Дунд      | Дунд<br>(өсгөх)      |

<sup>3</sup> 30 хувийн магадлалтай итгэх интервал

<sup>4</sup> Он тус бүрийн 4 дүгээр улирлын дундаж инфляц

<sup>5</sup> Сүүлийн 4 улирлын нийлбэрээс тооцсон өсөлт

## Засгийн газрын хэрэглээ

Төрийн албан хаагчдын цалин, урамшууллын нэмэгдэлтэй холбоотойгоор төсвийн бараа, үйлчилгээний зардал тайлант улиралд бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 26.1 хувиар тэлж, нийт эрэлтийг 3.7 нэгж хувиар дэмжлээ.

## Хөрөнгө оруулалт

Дөрөвдүгээр улиралд бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнээр бизнесийн зориулалттай зээл удаашран, төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дутуу байсны зэрэгцээ ГШХО-ын орох урсгал үргэлжлэн буурснаар нийт хуримтлал 60.2 хувиар саарч, нийт эрэлтэд -31.8 нэгж хувиар нөлөөлөв.

### Зураг II.4

Нийт хөрөнгийн хуримтлал үргэлжлэн буурав.



## Цэвэр экспорт

Цэвэр экспорт нийт эрэлтийг 31.1 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөөтэй байв. Тайлант улиралд экспорт бодит дүнгээр 23.5 хувиар өссөн бол импорт 11.4 хувиар агшлаа (Зураг II.5).

Тайлант улиралд зэсийн үнэ 2013 оноос хойших дээш түвшинд хүрч, экспорт нэмэгдэж, мөн алтны экспортын хэмжээ гурван улирал дараалан өндөр түвшинд хадгалагдсанаар нийт эрэлтийг 23.5 нэгж хувиар дэмжив.

## Зураг II.5

Гадаад худалдаа нийт эрэлтийг дэмжив



Импорт агшихад хөрөнгө оруулалтын зориулалттай тээврийн хэрэгсэл, машин механик, түүний сэлбэг, нефтийн бүтээгдэхүүн болон барилгын материалын хэмжээ буурсан нь нөлөөллөө.

## Эдийн засгийн салбарууд

Тайлант улиралд уул уурхайн салбар огцом өссөн хэдий ч уул уурхайн бус салбар -4.5 хувиар буурлаа. Боловсруулах, эрчим хүч, мэдээлэл холбооноос бусад салбарын үйлдвэрлэл агшив.

“Ногоон гарц” журам үргэлжлэн хэрэгжсэн, Оюу толгойн зэсийн баяжмал, түүнд агуулагдах алтны агууламж нэмэгдсэнээр уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтөд +4.2 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлээ.


Уул уурхайн салбар ийнхүү өсөхөд нүүрс, зэсийн баяжмал, алтны олборлолт голлох эерэг нөлөө үзүүлжээ. Тухайлбал, нүүрс олборлолт өмнөх улирлуудаас эргэн сэргэж, хүлээлтээс давлаа. Тайланд улиралд нүүрсний олборлолт өмнөх оны мөн үеэс 39 хувиар өсөв. Мөн Оюу толгойн зэсийн баяжмал 23.3 хувиар, үүнд агуулагдах алтны хэмжээ 57.6 хувиар нэмэгджээ. Оюу толгойн зэсийн баяжмалын алтны агууламж өмнөх оны мөн үеэс 2.6 дахин өссөн байна. Харин Оюу толгойгоос бусад зэсийн баяжмалын олборлолт 1 хувиар, алт олборлолт 5.3 тоннд хүрснээр өмнөх оноос 2.3 хувиар нэмэгдлээ.

Газрын тос, төмрийн хүдэр уул уурхайн салбарын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлжээ. Тухайлбал, төмрийн хүдэр 19.7 хувиар, газрын тос 5.2 хувиар агшив.

Хэдийгээр нүүрсний экспорт нэмэгдэж авто тээврийн ачаа тээвэр нэмэгдсэн ч төмрийн хүдрийн экспорт буурснаар төмөр замын ачаа тээвэр буурсан, мөн бүх төрлийн зорчигч тээвэр буурснаар тээврийн салбарын нэмүү өртөг тайлант улиралд 12.7 хувиар агшив.

### Зураг II.6

Газрын тос, төмрийн хүдрээс бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт 20.8 хувьд хүрлээ.



Тээврийн салбарын идэвхжил буурсантай холбоотойгоор шатахууны худалдаа саарч, мөн хөрөнгө оруулалтын шинжтэй машин тоног төхөөрөмжийн худалдаа буурснаар худалдааны салбарын өсөлт төсөөллөөс бага буюу -6.9 хувьд хүрэв. Зөвхөн эм, хүнсний худалдаа тайлант улиралд нэмэгджээ.

КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр томоохон төслийн барилгын ажил удааширч, орон сууцны болон орон сууцны бус бүх барилгын үйлдвэрлэл агшиж барилгын салбарын үйлдвэрлэл тайланд улиралд 8.5 хувиар агшлаа. Харин Таван толгой-Зүүн баян, Таван толгой-Гашуун Сухайт төмөр замын барилга нэмэгджээ.

Эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээ нэмэгдсэн ч үйлчилгээний бусад

байгууллагуудын үйл ажиллагаа тайлант улирлын ихэнх хугацаанд зогссон тул үйлчилгээний салбарын нэмүү өртөг 5.3 хувиар буурав.

2020 оны мал тооллогын дүнгээр том малын зүй бус хорогдол төсөөллөөс өндөр байснаар хөдөө аж ахуйн салбарын төсөөлөл хүлээлтээс бага байлаа. Хөдөө аж ахуйн салбар тайлант улиралд 10.4 хувиар агшив. Харин хүнсэнд хэрэглэсэн малын тоо нэмэгдсэний нөлөөгөөр боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 14 хувиар нэмэгджээ.


Эдийн засгийн идэвхжил суларч, авто машины импорт буурснаар бүтээгдэхүүний цэвэр татварын орлого тайлант улиралд 15.1 хувиар буурлаа.

### Потенциал үйлдвэрлэл

Уул уурхайн салбарт хийгдсэн бүтээн байгуулалтын нөлөөгөөр уул уурхайн бус салбар идэвхжиж, 2017-2019 онд потенциал үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдсэн бол КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, потенциал үйлдвэрлэл буурлаа (Зураг II.7).

### Зураг II.7

Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээлэл, тэдгээрийн хоорондын хамаарлыг ашигладаг олон хувьсагчийн Калман филтрийн үр дүнгээр потенциал үйлдвэрлэл алгуур буурч, 2020 оны эцэст 2 хувьд хүрсэн бол нэг хувьсагчийн HP филтр,


үйлдвэрлэлийн функцийн үр дүнгээр потенциал өсөлт илүү хурдтай буурах чиглэлд өөрчлөгджээ.

### Үйлдвэрлэлийн зөрүү

2019 оны туршид эерэг түвшинд байсан үйлдвэрлэлийн зөрүү цар тахлын нөлөөгөөр 2020 онд сөрөг боллоо. Тодруулбал, цар тахалтай холбоотойгоор эдийн засгийн үйл ажиллагаа хумигдаж, уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү жилийн туршид сөрөг байлаа. Харин уул уурхайн үйлдвэрлэл 2020 оны эхний хагаст огцом буурсан нөлөөгөөр үйлдвэрлэлийн зөрүү сөрөг байсан бол сүүлийн хагаст экспорт сэргэж, уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдсэнээр үйлдвэрлэлийн зөрүү багассан байна. (Зураг II.8). 2020 оны 4 дүгээр улиралд уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний олборлолт эрчимжиж, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн зөрүү эерэг түвшинд хүрснээр нийт зөрүү өмнөх улирлаас 2 орчим нэгж хувиар багасав.

### Зураг II.8

#### Үйлдвэрлэлийн зөрүү<sup>6</sup>



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

### Эдийн засгийн цаашдын төлөв

Эдийн засгийн өсөлт 2020 оны 4 дүгээр улиралд төсөөллийн орчимд байв. Цар тахлын сөрөг нөлөө зарим уул уурхайн бус салбаруудад өндөр байгаа, Эрдэнэт үйлдвэрийн зэсийн олборлолт энэ онд буурах төсөөлөлтэй байгаагаас шалтгаалан


энэ оны эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс ялимгүй буурахаар байна.

Ирэх онд дотоод эрэлт сэргэн уул уурхайн бус салбар идэвхжих хэдий ч Оюу толгойн зэсийн баяжмал, түүний алтны агууламж буурах нөлөөгөөр уул уурхайн үйлдвэрлэл буурч, эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс сааруулах нөлөө үзүүлэхээр байна. (Зураг II.9, Хүснэгт II.1.1).

**Уул уурхай:** Энэ онд гадаад эрэлт сэргэх, нүүрсний үйлдвэрлэл нэмэгдэх, Оюу толгойн зэсийн баяжмалын олборлолт, алтны агууламж сайжрах нь уул уурхайн салбарын өсөлтийг голлон тэтгэнэ. Харин шинэчилсэн мэдээллээр Эрдэнэт үйлдвэрийн зэсийн олборлолт өмнөх төсөөллөөс буурахаар байгаа тул уул уурхайн салбарын өсөлтийг өмнөх төсөөллөөс бууруулж авч үзлээ. Ирэх онд экспортын үнэ буурах, Оюу толгойн зэсийн баяжмал дахь металлын агууламж багасах нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт саарах хүлээлттэй байна.

### Зураг II.9

#### 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

**Уул уурхайн бус:** Уул уурхайн бус салбаруудын хувьд цар тахлын сөрөг нөлөө бүтээгдэхүүний цэвэр татвар, үйлчилгээний салбарт өндөр байсан тул дээрх салбаруудын үйлдвэрлэлийг энэ онд өмнөх төсөөллөөс бууруулав. Харин Засгийн газраас хэрэгжүүлж буй цахилгаан, дулаан, усны

<sup>6</sup> Калман филтрээр тооцсон.

төлбөрийг хөнгөлөх арга хэмжээний нөлөөгөөр эрчим хүчний салбарын өсөлт нэмэгдэх, мөн боловсруулах салбарын өмнөх саруудын гүйцэтгэл сайн гарсантай уялдуулан тус салбарын өсөлт энэ онд өмнөх төсөөллөөс сайжрахаар байна. Цар тахлын нөлөө харьцангуй бага ХАА, мэдээлэл холбоо, тээвэр агуулах зэрэг салбаруудын өсөлтийг өмнөх төсөөллийн орчимд байхаар авч үзлээ. Ирэх онд хөрөнгө оруулалт нэмэгдэж, дотоод эрэлт сэргэн эдийн засгийн үйл ажиллагаа сайжрах нөлөөгөөр уул уурхайн бус салбар идэвхжих төлөвтэй байна.

### Хүснэгт II.1.1

#### Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл<sup>7</sup>

|                    | 2020<br>гүйц. | 2021*<br>төсөөлөл | 2022*            |
|--------------------|---------------|-------------------|------------------|
| ДНБ-ий өсөлт, %    | -5.3          | 4.5 – 7.7         | 3.1 – 7.5        |
| Уул уурхайн, %     | -9.4          | 14.4 – 17.6       | (-10.1) – (-5.7) |
| Уул уурхайн бус, % | -4.3          | 2.0 – 5.2         | 6.8 – 11.2       |

Эх сурвалж: Монголбанк

### Хүснэгт II.1.2

#### Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт (2021)

| НИЙТ ЭРЭЛТ | Хүлээлт нэмэгдсэн |
|------------|-------------------|
| Хэрэглээ   | Хүлээлт хэвэндээ  |

- Засгийн газар, Төв банкнаас эрэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж байгаа ч бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед өрхүүд хэрэглээгээ танаж байна.
- Бэлэн байдлын зэрэг буурч, орон даяар вакцинажуулалт эхэлснээр эдийн засгийн идэвхжил оны сүүлийн хагаст сайжрах хүлээлттэй байна.

| Хөрөнгө оруулалт | Хүлээлт нэмэгдсэн. |
|------------------|--------------------|
|------------------|--------------------|

- Өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд үндсэн хөрөнгө хүлээлтээс давж агшсан суурь нөлөөгөөр 2021 оны эцэст өсөлт нэмэгдэх тооцоолоттой байна.
- Бэлэн байдлын зэрэг буурч, орон даяар вакцинажуулалт эхэлснээр эдийн засгийн идэвхжил оны сүүлийн хагаст сайжрах хүлээлттэй байна.

| НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ | Хүлээлт буурсан.       |
|-----------------|------------------------|
| Уул уурхай      | Төдийлөн өөрчлөгдөөгүй |

2021 оноос нүүрсний экспорт сэргэж, Зэсийн баяжмалын биет хэмжээ, алтны агууламж өсөх нь уул уурхайн салбарын өсөлтөд томоохон эерэг нөлөөтэй байхаар байна.

| Уул уурхайн бус | Хүлээлт буурсан. |
|-----------------|------------------|
|-----------------|------------------|

- 2021 оны эхний хагаст уул уурхайн бус салбарууд төдийлөн өсөхөөргүй байгаа бол дараагийн хагаст өсөлт нэмэгдэхээр байна.
- Цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс шалтгаалж 2021 оны эхний хагаст боловсруулах, барилга, худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний татварын орлого төдийлөн өсөхөөргүй байна.
- Нүүрсний экспорт сэргэхээс шалтгаалж авто тээврийн ачаа тээвэр сэргэснээр тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд томоохон эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Эх сурвалж: Монголбанк

### Эдийн засгийн цаашдын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал

| Эрсдэл, тодорхой бус байдал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Магадлал  | Нөлөө                |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|----------------------|
| КОВИД-19 цар тахал дотоодод тархаж, бүрэн хяналтад оруулах хугацаа тодорхойгүй байгаа нь төсөөллийн тодорхой бус байдлыг голлон үүсгэж байна. Хорио цээрийн дэглэм суларсантай холбоотойгоор вирусын тархалт огцом нэмэгдэх тохиолдолд хатуу хөл хорио тогтоох, эдийн засгийн үйл ажиллагаа хумигдах, ажилгүйдэл нэмэгдэх, гадаад худалдаа удаашрах, төсвийн орлого тасрах зэргээр эдийн засгийн өсөлтийг төсөөлснөөс муутгаж болзошгүй юм.                                                      | Дунд      | Дунд<br>(сөрөг)      |
| Дэлхийн эдийн засаг энэ онд сэргэж, манай гадаад худалдааны түнш орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөх төсөөллөөс нэмэгдлээ. Гэсэн хэдий ч вирусын тархалтыг хяналтдаа оруулах хугацаа тодорхойгүй хэвээр байна. Тухайлбал, вакцинжуулалтын хүрэлцээ муу байгаа улс оронд халдвар эрчимжих, вакцины үр дүн харилцан адилгүй байгаа нь хугацааг тодорхой бус болгосон хэвээр байна. Энэ нь дэлхийн эдийн засгийн сэргэлтийг хүлээлтээс удаашруулах, манай гадаад эрэлтэд сөрөг нөлөөтэй. | Бага-Дунд | Бага<br>(сөрөг)      |
| Нийгэм, эдийн засагт үүсээд буй өнөөгийн нөхцөл нь хэрэглэгч, хөрөнгө оруулагчийн зан төлөвийг өөрчлөн вирусыг бүрэн хяналтад оруулсан ч эдийн засаг хүлээлтэд хүрч хурдан сэргэхгүй байх эрсдэлтэй.                                                                                                                                                                                                                                                                                             | Бага-Дунд | Бага-Дунд<br>(сөрөг) |

<sup>7</sup> 30 хувийн магадлалтай итгэх интервал


### III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

#### III.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн насны хүн ам 2020 оны 4-р улиралд 2134.7 мянгад хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өссөн дүн юм. Гэсэн хэдий ч эдийн засгийн идэвхтэй хүн ам буурсан нөлөөгөөр ажиллах хүчний оролцооны түвшин буурав. Тодруулбал, ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар нэмэгдэж, улмаар ажиллах хүчний оролцооны түвшин 3.7 нэгж хувиар буурч 57.0 хувьд хүрчээ.

Зураг III.1.1

Хөдөлмөрийн насны хүн ам төдийлөн өсөөгүй байхад ажиллах хүчнээс гадуурх хүн ам нэмэгдэж байна<sup>8</sup>



Эх сурвалж: YCX


Ажиллагчдын тоо өмнөх улирлаас 51.4 мянгаар (-4.4%), өмнөх оноос 63.8 мянга (-5.4%)-аар тус тус буурч ажилгүйдлийн түвшин өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар нэмэгдэж 7.6 хувь болов. Ажилгүйдлийн түвшин ийнхүү багаар өссөн нь ажиллагсад эдийн засгийн идэвхгүй хүн ам руу шилжсэн буюу бүртгэлгүй ажилгүйдэл өссөнтэй холбоотой.

Тайлант улиралд хөдөлмөрийн насны хүн амын тоо төдийлөн өөрчлөгдөөгүй бол ажиллагчдын тоо буурснаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин<sup>9</sup> өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувь, өмнөх улирлаас 2.0 нэгж хувиар буурч 52.7 хувьд хүрсэн байна.

<sup>8</sup> Сүүлийн 4 улирлын дундаж өсөлт.

Зураг III.1.2

Ажилгүйдлийн түвшин алгуур нэмэгдэж, иргэдийн ажил хайх сонирхол буурч байна.



Эх сурвалж: YCX


Түүнчлэн, хөдөлмөр дутуу ашиглалтын түвшин өмнөх оны мөн үеэс нэг нэгж хувиар нэмэгдэж 13.0 хувьд хүрэв. Хөдөлмөр дутуу ашиглалтын түвшин ийнхүү өсөхөд ажилгүй иргэд эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжиж байгаа нь голлон нөлөөлж байна /Зураг III.1.2/.

#### Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Тайлант улиралд худалдаа, төрийн үйлчилгээ, мэдээлэл холбооноос бусад салбаруудын ажиллагчдын тоо буурлаа. Улмаар 2020 оны 4 дүгээр улиралд нийт ажиллагчдын тоо өмнөх улирлаас 4.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар тус тус буурсан байна.

Зураг III.1.3

Эдийн засгийн дийлэнх салбарт ажиллагчдын тоо буурлаа.




Эх сурвалж: YCX

<sup>9</sup> Хөдөлмөр эрхлэлтийн түвшин = Ажиллагчид / Хөдөлмөрийн насны хүн ам

Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо 2020 оны 4-р улиралд үргэлжлэн буурав. Тайлант улиралд ажиллагчдын тоо буурсан тул нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо өмнөх оноос буурч, харин сайн дураар даатгуулагчдын тоо нэмэгдсэн байна. Тухайлбал 2020 оны 12 дугаар сарын байдлаар албан журмаар даатгуулагчдын тоо 1.8 хувиар буурч, сайн дураар даатгуулагчдын тоо 3.3 хувиар өсчээ. Албан журмаар даатгуулагчдын тоог авч үзвэл хувийн хэвшлээс даатгуулагчдын тоо 3.3 хувиар буурсан. Нөгөөтэйгүүр, төсөвт байгууллагаас даатгуулагчдын тоо 1.9 хувиар нэмэгдсэн байна.

#### Зураг III.1.4

Сайн дураар даатгуулагчдын тоо өссөн ч албан журмаар даатгуулагчдын тоо үүнээс илүү хурдтайгаар буурч байгаа тул нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо буурч байна.



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

#### Ажилгүйдэл

Нийгмийн даатгалын сангаас 2020 онд 50.2 тэрбум төгрөгийн тэтгэмжийг (2019 оноос 15.3 хувиар өндөр) 21.4 (өмнөх оноос 1.7 мянгаар бага) мянган хүнд олгоод байна. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг

хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгож байна. 2020 онд давхардсан тоогоор 220.8 мянган даатгуулагчдад 44.1 тэрбум төгрөгийн дэмжлэгийг олгожээ<sup>10</sup>.

#### Зураг III.1.5

Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс цөөн байна.




Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Иргэдийн ажил хайх идэвх буурч ажилгүй иргэд эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу ажиллах хүчнээс гадуур хүн амд шилжиж байна. Тухайлбал, ажил идэвхтэй хайгаагүйгээс бүртгэлээс хасагдсан иргэд өмнөх оноос 12.6 мянга (19.6%)-аар буурав.

#### Зураг III.1.6

Иргэдийн хөдөлмөрийн захад оролцох оролцоо буурч байна.



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

<sup>10</sup> Үндэсний статистикийн хороо

<sup>13</sup> Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалингийн зардал.


## III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл

### III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

М2 мөнгөний жилийн өсөлт 2020 оны 2 дугаар улирлаас алгуур нэмэгдэх хандлага үргэлжилж байна. Тухайлбал, 2020 онд төсвийн шаардлагатай санхүүжилтийн дүн нэмэгдэж, уг зардлыг дотоодын банкны системд байрших эх үүсвэрээр болон гадаад зээлээр голлон санхүүжүүлсэн нь ЗГЦЗ болон ГЦА-ыг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлөв. М2 мөнгөний өсөлт 2021 оны 1-р сард 18 хувьд хүрч нэмэгдэхэд ЗГЦЗ 6 нэгж хувь, ГЦА 10 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлжээ. Харин банкны системийн зээлийн үлдэгдэл 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 17.1 их наяд төгрөгт хүрч жилийн 4.8 хувиар, тэтгэврийн зээл тэглэсэн нөлөөг засварлаж тооцвол 1 орчим хувиар буурчээ.

#### Зураг III.2.1.1

М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал




Эх сурвалж: Монголбанк

2020 онд төсвийн шаардлагатай санхүүжилтийн дүн 5.7 их наяд төгрөгт<sup>14</sup> хүрэв. Уг шаардлагатай санхүүжилтийн 2.1 орчим их наяд төгрөгийг Засгийн газар банкны систем дэх хуримтлалаас, 3.4 их наяд төгрөгийг гадаад зээлээр санхүүжүүлснээр Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) болон гадаад цэвэр актив (ГЦА) тус тус нэмэгдсэн байна (Зураг III.2.1.1).

Харин КОВИД-19 вирусийн тархалттай холбоотойгоор дотоод эдийн засгийн идэвхжил сул, зах зээл дээрх эрсдэл өндөр байгаа нь банкны системийн зээлийн нийлүүлэлтийг хязгаарлаж байна.

#### Зураг III.2.1.2

М2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал




Эх сурвалж: Монголбанк

М2 мөнгөний өсөлтийг банкны системийн эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламжийн өсөлт голлон бүрдүүлж байна. Тухайлбал, төгрөгийн хадгаламжийн өсөлт 13.7 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийн өсөлт 5 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг үзүүлэв. Түүнчлэн, төгрөгийн эх үүсвэрийн өсөлт нэмэгдэж байгаа нь эх үүсвэрийн долларжилт буурахад нөлөөлж байна.

#### Зураг III.2.1.3

Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

<sup>14</sup> Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 4 их наяд 539 тэрбум төгрөг, гадаад болон дотоод зээлийн үндсэн


төлбөрт 1 их наяд 140 тэрбум төгрөг зарцуулав. Бондын дахин санхүүжилтийг тусгаагүй дүн юм.



зориулалттай зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.7 нэгж хувиар буурч 21 хувьд, барилгын салбарын зээл 0.7 нэгж хувиар буурч 7 хувьд хүрэв. Харин үл хөдлөх, уул уурхай, худалдаа болон бусад үйлчилгээний салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь нийтдээ 4.4 орчим нэгж хувиар нэмэгджээ.

### Зураг III.2.1.6

Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Хугацаа хэтэрсэн зээлийн жилийн өсөлт 2021 оны 1 дүгээр сард 42.6 хувьд хүрч нэмэгдэв (Зураг III.2.1.6). Нийт хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үеэс 391 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний дийлэнх нь уул уурхай, худалдаа болон бусад үйлчилгээний салбарын зээлд хамаарч байна.

### Зураг III.2.1.7

Банкуудын хугацаа хэтэрсэн зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

Улмаар хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар нэмэгдэж, 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 7.7 хувьд хүрлээ. Харин чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 1.5 нэгж хувиар өсч, 11.8 хувь байна.

### III.2.2 Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2021 оны 3 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.

### Зураг III.2.2.1

БХЗ-ын хэлцлийн хүү



Эх сурвалж: Монголбанк


Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2021 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.63 нэгж хувиар өсч 6.28 хувьд хүрэв. Тодруулбал, ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 0.62 нэгж хувиар өсч 6.02 хувьд, банк хоорондын хадгаламжийн хүү 0.85 нэгж хувиар өсч 6.96 хувьд, ТБҮЦ-ны шууд хэлцлийн хүү 0.17 нэгж хувиар өсч 6 хувьд, банк хоорондын захын овернайт зээлийн хүү 0.05 нэгж хувиар нэмэгдэж 6.43 хувьд хүрсэн байна. Банкууд банк хоорондын зах дээр барьцаагүй зээл олгохдоо өндөр өгөөж эрэлхийлж байгаагаас үүдэн банк хоорондын хадгаламжийн хүү 2020 онд өндөр байв.

Энэ оны 1 дүгээр сард банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 2.69 нэгж хувиар буурч 7.9 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү 1.61 нэгж хувиар буурч

15.20<sup>18</sup> хувьд хүрлээ. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 1.08 нэгж хувиар өсч 7.30 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

### Зураг III.2.2.2

Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү мөн нэмэгдсэн байна. Үүнд шинээр олгосон гадаад валютын зээлийн дундаж хүү 2021 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.91 нэгж хувиар буурч 9.00 хувьд хүрсэн ч шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 1.57 нэгж хувиар буурснаар гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.65 нэгж хувиар нэмэгдэж 7 хувьд хүрэв.

### Хүснэгт III.2.2.1

Шинээр олгосон зээлийн хүү, зээлдэгчдээр (хөнгөлөлттэй зээлийг хассан)

| Хувь, %                     | 2020.01<br>сар | 2021.01<br>сар |
|-----------------------------|----------------|----------------|
| <b>Зээлийн хүү</b>          | 16.9           | 15.4           |
| i. Улсын байгууллага        | 2.7            | 3.5            |
| ii. Хувийн байгууллага      | 16.3           | 15.3           |
| iii. Санхүүгийн байгууллага | 18             | 15.7           |
| iv. Иргэд                   | 17.8           | 16.1           |
| v. Бусад                    | -              | 15.3           |


Эх сурвалж: Монголбанк

<sup>18</sup> 2021 оны 1 дүгээр сарын байдлаар хөнгөлөлттэй зээлийн хүүг хасч тооцвол зээлийн хүү 15.4 хувь байна.

<sup>19</sup> 2021 оны эхний 2 сарын байдлаар банкуудаас гадаад валютын дуудлага худалдаагаар худалдан авах саналын

### Зураг III.2.2.3

Бодлогын хүү болон шинээр олгосон зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк

### II.2.3 Валютын хани


Төгрөгийн ханш ам.долларын эсрэг сүүлийн 4 сар гаруйн хугацаанд 2850 төгрөгийн орчимд, 2021 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар 2849.27 төгрөгтэй тэнцэж байна (Зураг III.2.3.1).

Сүүлийн саруудад зах зээлийн хүлээлт тогтвортой байсны дээр экспортын үнэ, эрэлтийг даган гадаад валютын орох урсгал сайжирснаар төгрөгийн ханш сулрах дарамт бага байлаа. Тодруулбал, эхний 2 сарын байдлаар нүүрс, төмрийн хүдэр зэрэг экспортын гол бүтээгдэхүүний орлого өмнөх оноос өсч, орох урсгал өмнөх оны мөн үеэс 21 хувиар сайжирч, гарах урсгал 3.5 хувиар буурснаар гадаад валютын урсгал цэвэр дүнгээр 173.2 сая ам.долларын ашигтай гарав. Түүнчлэн, хөл хорионы хязгаарлалттай холбоотойгоор эдийн засгийн үйл ажиллагаа хумигдаж, валютын эрэлт буурсан байна.<sup>19</sup>

дундаж хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буурч, Монголбанкны спот арилжаагаар банкуудын цэврээр худалдан авсан валютын хэмжээ өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурчээ.

## Зураг III.2.3.1

## Төгрөгийн ам.доллартай харьцах ханш




Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) 2021 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар сулрав. Үүнд, төгрөгийн ханш рублийн эсрэг 13.5 хувиар чангарсан ч юань, еврогийн эсрэг харгалзан 11.1 хувь, 13.9 хувиар суларсан нь нөлөөлөв (Зураг III.2.3.2). Харин он гарснаас хойш төгрөгийн ханш еврогийн эсрэг алгуур чангарч эхэлсэн бол юанийн эсрэг үргэлжлэн сулрав. БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбар идэвхжиж, экспорт нь нэмэгдсэнээс гадна бусад орнуудтай харьцуулахад хүүгийн түвшин өндөр байгаа нь валютын дотогшлох урсгал нэмэгдэж, улмаар юанийн ханш дэлхийн зах зээл дээр чангарах гол нөхцлийг бүрдүүлж байна.

## Зураг III.2.3.2

## Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш, 2020 оны эхнээс




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн нэрлэсэн ханш суларч, гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ 0.7 хувиар буурснаар бодит ханш энэ оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар сул тогтлоо (Зураг III.2.3.3).

## Зураг III.2.3.3

## Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн 6 сарын турш эерэг түвшинд хадгалагдаж, 2020 оны эцэст 0.56 хувь, 2021 оны 1 дүгээр сард өмнөх сараас буурч 0.51 хувьтай байна (Зураг III.2.3.4). Төгрөгийн ханш өөрчлөлтгүй, тогтвортой байгаа ч төгрөгийн хадгаламжийн хүү буурч, хүүний зөрүү багассан нь төгрөгийн өгөөж өмнөх сараас буурахад нөлөөллөө.

## Зураг III.2.3.4

## Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк


### III.2.4 Хөрөнгийн зах зээл

захын идэвх сул байсан бол хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд сэргэлээ. Тодруулбал, хөрөнгийн захын ТОП-20 индексийн өсөлт үргэлжилж, зах зээлийн үнэлгээ түүхэн дээд хэмжээнд хүрэв.

#### Орон сууцны зах зээл

Зураг III.2.4.1

Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн өсөлт



ҮСХ-ны тооцооллоор Улаанбаатар хотод орон сууцны үнэ бага зэрэг буурч, орон сууцны үнийн ерөнхий индекс 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар, өмнөх улирлаас 0.3 хувиар тус тус буураад байв. Мөн түрээсийн үнийн өсөлт тайлант улиралд эрчимжиж, түрээсийн үнэ өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар, өмнөх улирлаас 1.7 хувийн өсөлттэй байв (Зураг III.2.4.1).

Харин “Тэнхлэг зууч” ХХК-ий тооцооллоор орон сууцны үнийн индекс 2020 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өссөн бол өмнөх улирлаас 1.3 хувиар буурчээ. Үүнд шинэ орон сууцны үнэ өмнөх улирлаас 4.6 хувиар буурсан нь нөлөөлөв (Хүснэгт III.2.4.1).

Үнэ-түрээсийн харьцааг орон сууцны үнийн хувьд ҮСХ болон “Тэнхлэг зууч”-ийн индексүүдийг ашиглан тус бүр тооцлоо.

Тооцооллоор орон сууцны үнийн индексүүд өмнөх улирлаас буурч, харин түрээсийн үнэ өссөнөөр үнэ-түрээсийн харьцаа 2020 оны 4 дүгээр улиралд үргэлжлэн буурав.

#### Хүснэгт III.2.4.1


Орон сууцны захын үзүүлэлтүүд

|                            |          | 2020-Q3 | 2020-Q4 |
|----------------------------|----------|---------|---------|
| Орон сууцны үнийн өсөлт, % |          |         |         |
| ҮСХ                        | улирлаар | 0.1     | -0.3    |
|                            | жилээр   | -0.4    | -0.1    |
| Тэнхлэг Зууч               | улирлаар | -0.9    | -1.3    |
|                            | жилээр   | 9.8     | 6.5     |
| Түрээсийн үнийн өсөлт, %   | улирлаар | 2.5     | 1.7     |
|                            | жилээр   | 5.7     | 6.9     |

Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

#### Зураг III.2.4.2

Үнэ-орлого ба үнэ-түрээсийн харьцаа



Харин тайлант улиралд өрхийн дундаж орлого 5.8 хувиар буюу орон сууцны үнээс давж буурсан нь орон сууцны үнэ-орлогын харьцаа өсөхөд нөлөөллөө (Зураг III.2.4.2). Мөн 2020 оны 4 дүгээр улиралд ипотекийн зээл шинээр авсан зээлдэгчийн тоо өмнөх улирлаас 11.0 хувиар, өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буурчээ<sup>20</sup>. Эдгээр үзүүлэлт нь тайлант улиралд орон сууцны худалдан авалтын идэвх харьцангуй сул байсныг илэрхийлж байна.


<sup>20</sup> Эх сурвалж: Монголбанк. Банкны өөрийн эх үүсвэрийн болон ОСИСТБХ-ийн зээлийг нийлүүлж тооцсон.

### Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн зах 2020 оны 4 дүгээр улирлаас идэвхжиж, ТОП-20 индекс оны эцэст буюу 12 дугаар сард дунджаар 18,126 нэгжид хүрсэн нь 2020 оны доод түвшин болох 6 дугаар сарын дунджаас 12.4 хувиар өссөн үзүүлэлт болж байна. ТОП-20 индексийн өсөлт 2021 он гарсаар үргэлжилж, 1 дүгээр сарын байдлаар өмнөх сарын дунджаас 10.5 хувиар өсөөд байна (Зураг III.2.4.3).

#### Зураг III.2.4.3

##### Хөрөнгийн захын голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 оны 12 дугаар сарын дунджаар оны эхнээс 13.6 хувиар өсч 3,027 тэрбум төгрөгт хүрсэн нь түүхэн дээд хэмжээ болов. Харин 2021 оны 1 дүгээр сард зах зээлийн үнэлгээ ялимгүй буурч 3,004 тэрбум төгрөгт хүрэв. Хөрөнгийн захын идэвхжилд МХБ дээр хувьцаагаа шинээр олон нийтэд нээлттэй санал болгосон компаниуд жилийн тайлангаа танилцуулсан, 2021 онд “Түмэн шувуут”, “ЛэндМН”, “Талх чихэр” зэрэг нийт 25 хувьцаат компани ногдол ашиг хуваарилахаа зарласан<sup>21</sup>, Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр арилжааны банкууд нээлттэй компани болох

зохицуулалт батлагдсан зэрэг зах зээлд эерэг хүлээлт бий болгосон нь голлон нөлөөлж байна. 2021 оны 1 дүгээр сарын байдлаар “Булган Ундарга”, “Монгол Алт”, “Ард Санхүүгийн Нэгдэл” зэрэг компаниуд хувьцааны ханшийн өсөлтөөр тэргүүлсэн бол “Оллоо”, “Глобал Монголиа Холдинг” компаниуд хамгийн өндөр уналтыг үзүүлжээ<sup>22</sup>.

#### Зураг III.2.4.4

##### Хөрвөх чадварын харьцаа



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Үнэт цаасны арилжааны дүн 2020 оны 12 дугаар сард огцом нэмэгдэн 14.7 тэрбум төгрөгт хүрсний дийлэнх хувийг хувьцааны хоёрдогч захын арилжаа эзлэв. Харин 2021 оны 1 дүгээр сард нийт 14.9 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд арилжааны идэвхийг “Бодь даатгал”, “Ард Кредит”, “ЛэндМН” компаниуд тоо ширхгээр тэргүүлж, “Ард Санхүүгийн Нэгдэл”, “Бодь даатгал”, “Эрдэнэ ресурс” компаниуд үнийн дүнгээр тэргүүлжээ. Хөрөнгийн захын идэвхжил сэргэн хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт 6.0 орчим хувьд хүрсэн нь сүүлийн гурван сарын дунджаас 3 дахин нэмэгдсэн үзүүлэлт болж байна (Зураг III.2.4.4).

<sup>21</sup> Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

<sup>22</sup> Эх сурвалж: Market info, www.marketinfo.mn

### III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

**Нэгдсэн төсөв 2020 онд:** Тэнцвэржүүлсэн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.5 их наяд төгрөг буюу нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 12.2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байв. Төсвийн тодотголтой харьцуулахад тэнцвэржүүлсэн орлого 300 тэрбум төгрөгөөр тасарсан бол нийт зардал 600 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байв (Хүснэгт III.3.1).

#### Хүснэгт III.3.1

##### Төсвийн үзүүлэлтүүд

| тэрбум төгрөг                     | 2020         |              |              | 2021         |             | 2021.01     |
|-----------------------------------|--------------|--------------|--------------|--------------|-------------|-------------|
|                                   | Бат.         | Тод.         | Урьд.Гүй.    | Бат.         | Гүй.        | Гүй %       |
| <b>Нийт орлого</b>                | <b>12900</b> | <b>10729</b> | <b>10402</b> | <b>13134</b> | <b>711</b>  | <b>90.6</b> |
| Ирээдүйн өв сан                   | 977          | 943          | 914          | 1180         | 23          | 47.4        |
| Тогтворжуулалтын сан              | 125          | 55           | 66           | 156          | 22          | 208.1       |
| <b>Тэнцвэржүүлсэн орлого</b>      | <b>11798</b> | <b>9731</b>  | <b>9422</b>  | <b>11798</b> | <b>666</b>  | <b>91.8</b> |
| Татварын орлого                   | 10656        | 8847         | 8502         | 10754        | 604         | 93.7        |
| Татварын бус орлого               | 1142         | 884          | 920          | 1043         | 62          | 77.1        |
| <b>Нийт зардал</b>                | <b>13873</b> | <b>14577</b> | <b>13961</b> | <b>13952</b> | <b>785</b>  | <b>71.6</b> |
| Анхдагч зардал                    | 12913        | 13605        | 13001        | 12992        | 752         | 71.0        |
| Урсгал зардал /-хүүний зардал/    | 9060         | 10178        | 9912         | 10052        | 660         | 71.3        |
| Хөрөнгийн зардал                  | 3806         | 3408         | 3052         | 3498         | 94          | 58.0        |
| Цэвэр зээл                        | 47           | 19           | 38           | -559         | -2          | 5.8         |
| Хүүний зардал                     | 960          | 973          | 959          | 1138         | 32          | 89.2        |
| <b>Нийт тэнцэл</b>                | <b>-973</b>  | <b>-3848</b> | <b>-3559</b> | <b>-818</b>  | <b>-73</b>  |             |
| ДНБ-д эзлэх хувь                  | -2.4%        | -9.9%        | -9.5%        | -1.9%        | -0.2%       |             |
| <b>Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл</b> | <b>-2075</b> | <b>-4847</b> | <b>-4539</b> | <b>-2154</b> | <b>-118</b> |             |
| ДНБ-д эзлэх хувь                  | -5.1%        | -12.5%       | -12.2%       | -5.1%        | -0.3%       |             |
| Анхдагч тэнцэл                    | -1115        | -3874        | -3580        | -1016        | -86         |             |
| ДНБ-д эзлэх хувь                  | -2.7%        | -10.0%       | -9.6%        | -2.4%        | -0.2%       |             |

Эх сурвалж: Сангийн яам


**Нэгдсэн төсөв 2021 оны эхэнд:** 2021 оны нэгдүгээр сарын эхний 10 хоногт хатуу хөл хорио үргэлжлэн, эдийн засгийн үйл ажиллагаа хязгаарлагдсанаар татварын орлого 93.7 хувийн гүйцэтгэлтэй төвлөрөв. Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй тэтгэвэр, тэтгэмжийн нэмэлт зардлын нөлөөгөөр татаас, шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 46 хувиар өсчээ.

**Тэнцвэржүүлсэн орлого:** Цар тахлын улмаас 2020 оны ихэнх саруудад орон даяар хөл хорионы дэглэм тогтоож, эдийн засгийн идэвхжил суларсан нөлөөгөөр тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос **1.5 их наяд төгрөгөөр хумигджээ**. Үүнийг орлогын бүрэлдэхүүнээр өмнөх онтой харьцуулан үзвэл:

- Нийгмийн даатгалын орлого – **442 тэрбум төгрөгөөр**
- Орлогын албан татвар (ОАТ) – **335 тэрбум төгрөгөөр**
- Импорттой холбоотой орлого – **236 тэрбум төгрөгөөр**
- Татварын бус орлого – **172 тэрбум төгрөгөөр тус тус агшжээ.**

#### Зураг III.3.1

##### Төсвийн орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Тэнцвэржүүлсэн орлого 2021 оны эхний сард өмнөх оны мөн үеэс 6 хувь буюу 42 тэрбум төгрөгөөр бага төвлөрөв. Үүнд, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, НӨАТ-ын орлого тус бүр 15 хувиар агшсан бол бусад бүлгийн орлого өмнөх оны түвшинд хадгалагджээ (Зураг III.3.1).

**Нийт зардал, цэвэр зээл:** Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлсэн багц арга хэмжээний нөлөөгөөр төсвийн зардал 2020 онд өмнөх оноос **2.3 их наяд төгрөг буюу 19.7 хувиар тэлэв**. Зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх онтой харьцуулахад:

- Татаас, шилжүүлэг – **1'670 тэрбум төгрөгөөр**
- Бараа, үйлчилгээний зардал – **875 тэрбум төгрөгөөр**
- Хөрөнгийн зардал – **35 тэрбум төгрөгөөр өсчээ.**

Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж, өндөр насны тэтгэвэр, халамжийн тэтгэвэр зэрэг нийгмийн халамж, даатгалын шилжүүлгийг нэмэгдүүлэх арга хэмжээ 2021 оны эхний

хагаст хэвээр үргэлжлэх төлөвлөгөөтэй байна.

### Зураг III.3.2

#### Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

**Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр:** Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 61.9 хувь байхаар батлагдсан нь хуульд заасан хязгаарыг хангаж байна (Хүснэгт III.3.2). Цар тахалтай холбоотойгоор “Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай” хууль батлагдсанаар өрийн хязгаарын тусгай шаардлагын хугацаа 1 жилээр хойшилж, 2021 онд 70.0 хувь байхаар тусгагдсан билээ.

### Хүснэгт III.3.2

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

| тэрбум төгрөг                           | 2018        | 2019        | 2020*       | 2021*       |
|-----------------------------------------|-------------|-------------|-------------|-------------|
|                                         | Гүй.        | Гүй.        | Тод.        | Бат.        |
| Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)            | 18956       | 20526       | 24064       | 26141       |
| ДНБ-д эзлэх хувь (ӨҮЦ-ээр тооцсон)      | 58.9        | 55.6        | 62.2        | 61.9        |
| <b>Өрийн хязгаар (ДНБ-д эзлэх хувь)</b> | <b>80.0</b> | <b>75.0</b> | <b>70.0</b> | <b>70.0</b> |
| Зээлийн үйлчилгээний төлбөр             | 1046        | 861         | 973         | 1138        |
| Төсвийн орлогод эзлэх хувь              | 11.3        | 8.0         | 10.0        | 9.6         |
| Төсвийн тэнцэл                          | 12          | -628        | -4847       | -2154       |
| ДНБ-д эзлэх хувь                        | 0.0         | -1.7        | -12.5       | -5.1        |

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

**Засгийн газраас хэрэгжүүлж буй хөнгөлөлтүүд:** Цар тахлын үед иргэдэд тулгарах санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор Засгийн газраас дараах үнийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлж байна. Үүнд,

- Улсын хэмжээнд бүх айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл тэглэв. Үүнтэй холбогдох 650 тэрбум төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар санхүүжүүлж байна.
- Сайжруулсан шахмал түлшний үнийг 75 хувиар хөнгөлснөөр нэг тонн шахмал түлшний үнэ 37.5 мянган төгрөг, нэг шуудай шахмал түлшний үнэ 937 төгрөг болж буурав. Үнийн хөнгөлөлттэй холбогдох 69 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Тавантолгой” хариуцаж байна.

## IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

### IV.1 Гадаад эдийн засгийн орчны талаарх төсөөлөлд ашигласан таамаглал<sup>23</sup>


Өмнөх улирлын төсөөлөлтэй харьцуулахад Хятадын эдийн засгийн өсөлтийн төлөв 2021 онд сайжирч, 2022 онд бага зэрэг муудахаар байна. Харин Евро бүс, ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2021 онд буурч, 2022 онд сайжирлаа.

#### Гадаад эрэлт<sup>24</sup>

Шинжээчид<sup>25</sup> Хятадын эдийн засгийн 2021 оны өсөлтийг 7.7-8.7 хувийн хооронд төсөөлсөн нь дунджаар 8.3 хувь<sup>26</sup> буюу өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар шнэмэгдсэн дүн юм. Аж үйлдвэрлэл, нийт хөрөнгө оруулалт, жижиглэн худалдаа өссөн нөлөөгөөр Хятадын 2020 оны 4-р улирлын эдийн засгийн гүйцэтгэл хүлээлтээс давж 6.5 хувиар өсөв. Аж үйлдвэрлэлийн сэргэлт 2021 оны 2-р сард хадгалагдаж, PMI индекс 50.9-д хүрч тэлэлт үргэлжлэв.

#### Зураг IV.1.1

Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: Блүмберг, EIU, Рубини, ОУВС

Мөн үйлчилгээний салбарын сэргэлт үргэлжилж тайлант хугацаанд аж үйлдвэрлэлийн бус PMI индекс 2021 оны 2-р сард 51.4 хүрч 11 дэх сардаа дараалан

<sup>23</sup>Худалдааны түнш орнуудын өсөлт, инфляцын төсөөллийг 2020 оны 11-р сарын 17-ны байдлаарх гадаад орчны төлөв, The EIU-ийн 2020 оны 11-р сарын тайлан, Рубини агентлагийн 11-р сарын тайлан болон Блүмбергийн судлаачдын төсөөллүүдийн медиан утгаас авч, зохих тайлбарыг эдгээр тайлангуудаас нэгтгэн оруулсан. Үүнд Монголбанкны судлаачийн үнэлэлт, дүгнэлт ороогүй болно.

<sup>24</sup>Гадаад эрэлтийг Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд эзлэх жингээр худалдааны гол түнш орнуудын

өслөө. Дэлхий дахинаа КОВИД-19-ийн тархалтын олон давалгаа дэгдэх эрсдэл байгаагийн дээр тодорхой бус байдал төдийлөн буураагүй тул цаашид төсөв, мөнгөний бодлогоор дотоод эрэлт, өсөлтийг дэмжих хандлага хэвээр байна.

Харин 2022 оны Хятадын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл дунджаар 5.4 хувь буюу өмнөхөөс 0.1 нэгж хувиар буурав. Өрхийн хэрэглээний өсөлт цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрэх болоогүй, өмнөх оны суурь нөлөө, жижиглэн худалдааны өсөлт, аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл хүлээлтэд хүрч сайжрахааргүй байгаа нь үүнд голлон нөлөөлж байна. Харин ирэх 5 жилд Хятадын засгийн газраас хэрэгжүүлэх “dual circulation” бодлого хэрэглээ, эдийн засгийн өсөлтийн тэтгэх хүлээлттэй байна.

#### Хүснэгт IV.1.1

##### Гадаад секторын төсөөллийн таамаглал

| Өмнөх төсөөлөл (2021)                                                                                                                                                                                                                                                                                                                         | Одоогийн төсөөлөл (2021)                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Гадаад эрэлт</b>                                                                                                                                                                                                                                                                                                                           | <b>Төсөөлөл сайжирсан</b>                                                                                                                                                                                                                                                                                                              |
| БНХАУ, Евро-бүсийн эдийн засгийн өсөлтүүд өмнөх төсөөллөөс сайжрахаар бол ОХУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс буурахаар байна.                                                                                                                                                                                                        | БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс сайжрахаар бол Евро-бүс, ОХУ-ын эдийн засгийн өсөлтүүд өмнөх төсөөллөөс буурахаар байна.                                                                                                                                                                                                 |
| <b>Худалдааны нөхцөл</b>                                                                                                                                                                                                                                                                                                                      | <b>Төсөөлөл сайжирсан</b>                                                                                                                                                                                                                                                                                                              |
| БНХАУ, Евро-бүсийн эдийн засгийн идэвхжил өмнөх төсөөллөөс сайжирсан, КОВИД-19-ийн эсрэг вакцины туршилтууд амжилттай болсон тул түүхий эдүүдийн эрэлтэд эерэгээр нөлөөлж үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Харин вакцины туршилт амжилттай болсон нь дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулж алтны эрэлт, үнийн төсөөлөл буурав. | БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил өмнөх төсөөллөөс сайжирсан, КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт амжилттай үргэлжилж байгаа тул түүхий эдүүдийн эрэлтэд эерэгээр нөлөөлж үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдэв. Харин вакцинжуулалт үргэлжилж байгаа нь дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдлыг бууруулж алтны эрэлт, үнийн төсөөлөл буурав. |
| <b>Гадаад хүү</b>                                                                                                                                                                                                                                                                                                                             | <b>Төсөөлөл хэвэндээ</b>                                                                                                                                                                                                                                                                                                               |
| ХНБ 2020 оны 11-р сард хүүгээ 0.0-0.25%-д хэвээр үлдээв. Цаашид 2022 оны төгсгөл хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаар байна.                                                                                                                                                                                                    | ХНБ 2021 оны 3-р сард хүүгээ 0.0-0.25%-д хэвээр үлдээв. Цаашид 2022 оны төгсгөл хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаар байна.                                                                                                                                                                                              |
| <b>Гадаад инфляц</b>                                                                                                                                                                                                                                                                                                                          | <b>Төсөөлөл сайжирсан</b>                                                                                                                                                                                                                                                                                                              |
| Худалдааны түнш орнуудын өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс сайжирснаар гадаад эрэлт хүлээлтээс нэмэгдсэн ч, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал буураагүй, эдийн засгийн сэргэлт хэвийн түвшинд хүрээгүй, газрын тосны үнэ төсөөллийн орчимд байхаар байгаа зэргээс шалтгаалан гадаад инфляцын төсөөлөл буурчээ.                           | Худалдааны түнш орнуудын өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс сайжирснаар гадаад эрэлт хүлээлтээс нэмэгдсэн, газрын тосны үнэ төсөөллөөс нэмэгдсэн зэргээс шалтгаалан гадаад инфляцын төсөөлөл нэмэгдэв.                                                                                                                                    |

Эх сурвалж: Гадаад эх сурвалжуудаас хийсэн дүгнэлт

ОХУ-ын эдийн засаг 2021 онд 2.9-3.1 хувийн хооронд, дунджаар 3.0 хувиар өсөхөөр<sup>27</sup> байгаа нь өмнөх төсөөллөөс 0.1

эдийн засгийн өсөлтийг жигнэж тооцов. (Үүнд: БНХАУ 0.90, ОХУ 0.02, Евро бүс 0.08)

<sup>25</sup> EIU, Блүмберг ба Рубини судалгааны байгууллага

<sup>26</sup> 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн байдлаарх ОУВС, EIU, Блүмберг, Рубини судалгааны байгууллагуудын дундаж төсөөлөл.

<sup>27</sup> 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн байдлаарх ОУВС, EIU, Блүмберг, Рубини судалгааны байгууллагуудын дундаж төсөөлөл.

нэгж хувиар буурсан төсөөлөл юм. 2020 оны 4-р улиралд ОХУ-д цар тахлын тархалт эрчимжин, хөл хорио чангарсан хэдий ч аж үйлдвэрлэл, экспорт, импортын агшилт багасч, эдийн засаг хүлээлтээс сайн буюу 2.6 хувиар агшлаа. ОХУ-ын засгийн газрын үндэсний дэд бүтцийн хөтөлбөрүүд хэрэгжих хугацаа хойшилсон, газрын тосны эрэлт хүлээлтээс нэмэгдэх төлөвтэй ч цар тахлын өмнөх түвшинд хүрэх болоогүй зэрэг нь 2021 оны өсөлтийн төлөвийг бууруулах шалтгаан болов. Оросын Төв банк энэ оны 2-р сарын хурлаар бодлогын хүүг 4.25 хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргасан бөгөөд энэ оны туршид тус түвшинд хадгалах хүлээлттэй. Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулах хүрээнд 2020, 2021 онуудад батлагдсан 6.4 их наяд рублийн багц хөтөлбөрүүд үргэлжлэн хэрэгжсэнээр төсвийн алдагдал энэ онд ойролцоогоор ДНБ-ий 2.4 хувьтай тэнцэхээр байна<sup>28</sup>.

2022 онд ОХУ-ын ДНБ 2.1-2.5 хувийн хооронд, дунджаар 2.3 хувиар өсөх төсөөлөлтэй буюу өмнөхөөс 0.2 нэгж хувиар нэмэгдэв. Үүнд; 1) өрхийн хэрэглээ өмнөх төсөөлөлд 2022 онд 2.8 хувиар өсөхөөр байсан бол одоогийн төсөөллөөр 3.1 хувиар өсөх, 2) нийт хөрөнгө оруулалт 4.5 хувиар өсөхөөр байсан бол шинэчилсэн төсөөллөөр 4.6 хувиар өсөхөөр байгаа нь нөлөөллөө. 2021 оны 1-р сарын байдлаар өмнөх онд хэрэгжиж байсан татварын зарим хөнгөлөлтүүд<sup>29</sup> дуусгавар болсон, ОХУ-ын 2021-23 оны улсын төсвийн төслөөр төсвийн зарцуулалт 10 хувиар хумигдахаар байгаа тул төсвийн алдагдал 2022 онд ДНБ-ий 1.2 хувь хүрч буурахаар байна. Төсөөллийн хугацаанд ОПЕК+ нэгдлийн хүрээнд түүхий нефть, газрын тосны үйлдвэрлэл үргэлжлэн буурах төлөвтэйн дээр барууны орнуудын худалдааны хориг зөөлрөх нөхцөл бүрдээгүй нь эрсдэл үүсгэсэн хэвээр байна.

**Евро бүсийн эдийн засаг** 2021 онд 4.2-4.7 хувийн хооронд, дунджаар 4.4 хувиар

өсөхөөр шинжээчид таамаглаж байна. Энэ нь өмнөхөөс 1.0 нэгж хувиар буурсан дүн юм. Евро бүсийн **өрхийн орлого**, нийт **хөрөнгө оруулалт** өмнөх оны сүүлийн улиралд эрс нэмэгдэж эерэг өсөлттэй гарч, аж үйлдвэрлэлийн салбар дахь **үйлдвэрлэлийн** агшилт буурснаар 4-р улирлын гүйцэтгэл хүлээлтээс сайн байв. Хэдийгээр вакцинжуулалт эхэлсэн, 4-р улирлын гүйцэтгэл хүлээлтээс сайн байсан ч КОВИД-19-ийн олон давалгаа дэгдэх эрсдэл, тодорхой бус байдал төдийлөн буураагүй тул эдийн засгийн сэргэлтийн эрч төсөөллөөс удаан байх төлөвтэй болж, бүсийн аж үйлдвэрлэл, өрхийн хэрэглээ, Засгийн газрын хэрэглээний өсөлт өмнөх төсөөллөөс буурахаар болж, улмаар энэ нь 2021 оны төсөөллийг бууруулах шалтгаан болов.

2022 оны төсөөлөл 3.6-4.4 хувийн хооронд буюу дунджаар 4.0 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа нь өмнөхөөс 0.8 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Европын Төв банкны хасах хүүгийн бодлого, уламжлалт бус мөнгөний бодлого болон бүсийн голлох эдийн засгуудад хэрэгжүүлж буй төсвийн тэлэх бодлого нь дотоод эрэлтийг тэтгэх хүлээлттэй, дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв нэмэгдсэнээр гадаад эрэлт өмнөх төсөөллөөс сайжирч, вакцинжуулалтын явц зэргээс шалтгаалан 2022 оны бүсийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлэв. Мөн өрхийн хэрэглээ өмнөх төсөөлөлд 2022 онд 3.2 хувиар өсөхөөр байсан бол одоогийн төсөөллөөр 4.0 хувиар, нийт хөрөнгө оруулалт 5.0 хувиар өсөхөөр байсан бол 5.1 хувиар тус тус өсөхөөр байгаа нь өсөлтөд дэмжлэг болохоор байна.

### Худалдааны нөхцөл

ҮСХ-ны тооцоогоор **Гадаад худалдааны нөхцөл** 2021 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар сайжирлаа. Экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар нэмэгдсэн бол импортын үнэ 3.1 хувиар буурчээ.

Экспортын үнэ нэмэгдэхэд зэсийн экспортын хилийн үнэ 57.9 хувиар,

<sup>28</sup> ОХУ-ын ЗГ-аас төсвийн алдагдал ДНБ-ий 2.4 хувьтай тэнцэнэ гэж тооцоолсон бол ЕІU байгууллага төсвийн алдагдал ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэнэ гэж үзэж байна.

<sup>29</sup>Олборлох үйлдвэрлэлийн салбар дахь хөнгөлөлтийн хугацаа дууссан. 68,000 ам.доллараас дээш орлоготой иргэдийн орлогын албан татварын хувийг 13 хувиас 15 хувь хүргэж нэмэгдүүлсэн.


төмрийн хүдрийн хилийн үнэ 66.7 хувиар, нүүрсний үнэ 5.4 хувиар өссөн нь эерэгээр нөлөөлөв. Харин боловсруулаагүй нефтийн хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар, ноолуурын үнэ 37.6 хувиар буурсан нь сөргөөр нөлөөлөв.

Хэрэглээний импортын үнэ 1-р сард өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар, хөрөнгө оруулалтын импортын үнэ 7.9 хувиар, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний импортын үнэ 5.1 хувиар тус тус өссөн хэдий ч дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ нам түвшинд хадгалагдаж байгаа тул нефтийн бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 26.1 хувиар хямдарсан нөлөө давамгайлж, нийт импортын үнэ 3.1 хувиар буурчээ.

**Худалдааны нөхцөл 2021 онд өмнөх төсөөллөөс сайжрахаар байна** (Зураг IV.1.2). Үүнд зэс, нүүрс, төмрийн хүдрийн экспортын үнийн төсөөлөл нэмэгдсэн нь нөлөөлөв. Дэлхийн улс орнуудад КОВИД-19-ын вакцинжуулалт үргэлжилж, эдийн засаг сэргэн, түүхий эдийн эрэлт нэмэгдэх төлөвтэйн дээр нийлүүлэлт талдаа зэс, төмрийн хүдрийн нийлүүлэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа нь үнэд эерэгээр нөлөөлж байна. Хятадын Засгийн газраас барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд ган, төмрийн хүдрийн эрэлт өндөр байгаагаар холбоотой нүүрсний эрэлт, үнэ нэмэгдээд байна.

#### Зураг IV.1.2

Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол


Харин вакцинжуулалт амжилттай үргэлжилж буй нь зах зээлд оролцогчдын

итгэлд эерэгээр нөлөөлж алтны үнэ буурав. 2022 онд зэс, нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны үнэ өсөхөөр байгаа бол алтны үнэ буурахаар байна. Улмаар экспортын үнэ импортын үнэ нэмэгдэх нөлөөгөөр худалдааны нөхцөл 2022 онд өмнөх төсөөллөөс сайжрах хүлээлттэй.

**Гадаад хүү:** АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас эдийн засгаа 2021 онд 6.5 хувиар өсөхөөр төсөөлж, 2021 оны 3-р сард бодлогын хүүгээ 0.0-0.25%-д хэвээр хадгалах, сар тутам 120 тэрбум ам.долларын бонд худалдан авах хөтөлбөрөө цаашид үргэлжлүүлэхээр шийдвэрлэв.

#### Зураг IV.3.5

Холбооны нөөцийн банкны хүү, хувиар



Эх сурвалж: Блүүмберг

Түүнчлэн, Холбооны нөөцийн банкнаас урт хугацааны бүрэн ажил эрхлэлтийн түвшин болон инфляцын 2 хувийн зорилтот түвшин хангагдаж, эдийн засгийн идэвхжил хямралын өмнөх түвшинд хүрэх хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаа мэдэгдлээ. Цар тахлын нөлөөг саармагжуулах, өсөлтийг дэмжих хүрээнд 2021 оны 3-р сард батлагдсан 1.9 их наяд ам.долларын төсвийн багц АНУ-ын эдийн засгийн өсөлтийг тэтгэх хүлээлттэй.

**Гадаад инфляцын** төлөв өмнөх төсөөллөөс буурав. Хятадын инфляцыг Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын дунджаар 2.5 хувиас 1.5 хувь болгож бууруулав. Дотоод эрэлт хэвийн түвшинд хүрээгүй, гахайн мялзан өвчний улмаас буураад байсан гахайн махны нийлүүлэлт сэргэсэн зэрэг нь инфляцын төсөөлөл буурах гол үндэс болжээ.

ОХУ-ын инфляц 2021 онд Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын дунджаар 3.9 хувиас 4 хувь болж бага зэрэг нэмэгдэхээр

байна. Мөнгөний зөөлөн бодлого, дотоод эрэлтийн сэргэлт хадгалагдахаар байгаа нь инфляц өмнөх төсөөллөөс бага зэрэг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүллээ. Дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн нөлөөгөөр 2021 оны 2-р сард инфляц өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өсөв. Харин оны эхэнд ажиглагдсан эдийн засгийн огцом сэргэлт аажмаар тогтворжиж, рублийн ханш 2020 оны түвшнээс чангарах нөлөөгөөр инфляц цаашид 2-р сарын түвшнээс буурч тогтворжихоор байна.

АНУ-ын инфляц 2021 онд Блүүмберг, EIU судалгааны байгууллагуудын төсөөллийн дунджаар 1.8 хувиас 2.0 хувь болж нэмэгдэхээр байна. Ажилгүйдлийн түвшин 2021 онд 6.0 хувь хүртэл буурах төлөв, газрын тосны үнэ нэмэгдэх төсөөлөл, дотоод эрэлтийн сэргэлт, эдийн засгийн өсөлтийн дэмжих төсвийн багц батлагдсан, Холбооны нөөцийн банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлого зэргээс үүдэн төсөөлөл ийнхүү нэмэгдэв.

Евро бүсийн инфляцыг 2021 онд Блүүмберг, Рубини судалгааны байгууллагуудын төсөөллийн дунджаар үзвэл 0.8 хувиас 1.1 хувь болж нэмэгдлээ. Бүсийн эдийн засгийн идэвхжил, дотоод эрэлт өмнөх төсөөллөөс буурахаар байгаа ч газрын тосны үнэ өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байгаа нь инфляц нэмэгдэх гол шалтгаан болов.

#### **Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал**

Дэлхий дахинд цар тахлын хоёр, гурав дахь давалгаа эрчээ авч буй байдал болон КОВИД-19-ийн вакцинжуулалтын хурд ямар түвшинд байх нь гадаад орчны тодорхой бус байдлын гол сурвалж болж байна. Эрчимжиж буй цар тахлын тархалт, вирусын шинэ хувилбараас сэргийлж улс орнууд хөл хориог чангатгах тохиолдолд дэлхийн эдийн засгийн идэвхжил хүлээлтээс саарч болзошгүй. Мөн АНУ, Хятадын хоорондын худалдааны хязгаарлалтууд хэрхэн үргэлжлэх, хоёр улсын хоорондын таагүй харилцаа даамжрах эрсдэлзэрэг геополитикийн тодорхой бус байдлууд хэвээр байна.

#### **IV.2 Түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ**

*Дэлхийн улс орнуудад КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт үргэлжилж, эдийн засаг сэргэн, түүхий эдийн эрэлт, үнэ нэмэгдэх хандлагатай болов. Харин тодорхой бус байдал багассантай холбоотойгоор алтны үнийн төсөөлөл буурлаа.*

**Зэс:** Нэг тонн зэсийн үнэ 2021 оны 1-р сард дунджаар \$7972 ам.доллар байсан бол 2-р сард дунджаар \$8436 хүрч өсөв. Хятадын эдийн засаг, үйлдвэрлэлийн сэргэлт үргэлжилж, АНУ-ын Засгийн газраас эдийн засгаа дэмжих 1.9 их наяд ам.долларын нэмэлт төсөв батлагдсан болон улс орнуудад цар тахлын вакцинжуулалт үргэлжилж эдийн засаг сэргэж байгаа нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ өсөх шалтгаан болов. Мөн зэсийн гол үйлдвэрлэгч Перү, Чили зэрэг улсуудад цар тахлын тархалт төдийлөн буураагүй, цар тахлын дараагийн давалгаа үүсч болзошгүй тул 2021 онд нийлүүлэлтийн хомсдол үүсэх эрсдэл нь зэсийн үнийг дэмжих нөлөөтэй байна. Зэсийн үнэ Блүүмберг, Рубини, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын шинжээчдийн төсөөллийн дунджаар 2021 онд \$7702/тонн, 2022 онд \$7923/тонн хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэх хүлээлттэй. АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан даамжрах, КОВИД-19-ийн тархалт үргэлжилж, олон давалгаа үүсч болзошгүй нь төсөөллийн хугацаанд металлын эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

**Алт:** 2021 оны 1-р сард алтны үнэ дунджаар 1847 ам.доллар/унци байсан бол 2-р сард дунджаар 1734 ам.доллар/унци хүрч буурав. Вакцинжуулалт эрчимжиж, тодорхой бус байдал буурснаар үнэ ийнхүү буурав. Дэлхий дахинд КОВИД-19-ийн тархалт нэмэгдэж, цар тахлын олон давалгаа гарч болзошгүй, худалдааны маргаан даамжрах эрсдэлтэй зэрэг нь аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны үнэ огцом унахгүй байхад нөлөөлж байна. Блүүмберг, Рубини, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын шинжээчдийн төсөөллийн дунджаар алтны үнэ 2021 онд \$1737/унци,

2022 онд \$1666/унци хүрч өмнөх төсөөллөөс буурах хүлээлттэй.

**Коксжих нүүрс:** Хятадын дотоодын нүүрс үйлдвэрлэл, тэр дундаа ӨМӨЗО-ны үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 25 хувиар өсч, 1-р сард 95.3 сая тоннд хүрсэн, голлох цахилгаан станцуудын нөөц нэмэгдсэн нөлөөгөөр 2021 оны 2-р сард коксжих нүүрсний үнэ 130 ам.доллар/тоннд хүрч нэмэгдэв. Үүний зэрэгцээ Хятадын Засгийн газраас барилгын салбараа эрчимтэй дэмжиж байгаагийн үр дүнд ган, төмрийн хүдрийн эрэлт нэмэгдэх төлөвтэй тул богино хугацаанд коксжих нүүрсний эрэлт, үйлдвэрлэл үргэлжлэн нэмэгдэх хүлээлттэй. Коксжих нүүрс үйлдвэрлэлийн секторт түлхүү хэрэглэгддэг тул АНУ, Хятадын худалдааны маргаан даамжрах эрсдэл, дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал төдийлөн буураагүй байдал нь энэ онд Хятадын бодит сектор, ган, аж үйлдвэрлэлийн өсөлтийн төсөөллийг сааруулж, коксжих нүүрсний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй. Коксжих нүүрсний үнэ Блүүмберг, Австралийн Нөөц эрчим хүч, KPMG байгууллагын төсөөллийн дунджаар 2021 онд \$141/тонн, 2022 онд \$ 148/тонн хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэх хүлээлттэй.

**Төмрийн хүдэр:** Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 2-р сард \$159 байв. Хятадын Засгийн газраас барилгын салбараа эрчимтэй дэмжсэний үр дүнд томоохон хотуудад гангийн үйлдвэрлэлийн идэвхжил нэмэгдэж, төмрийн хүдрийн эрэлт эрс нэмэгдлээ. Мөн Бразил дахь КОВИД-19-ийн тархалттай холбоотойгоор “Vale” уурхай хүчин чадлаасаа доогуур ажиллаж, нийлүүлэлтээ нэмэгдүүлэхээргүй байгаа нь нийлүүлэлт талаас үнэ нэмэгдэхэд нөлөөлөв. Төмрийн хүдрийн нийлүүлэлтийн хомсдол үүсч болзошгүйн зэрэгцээ эрэлт өндөр байх төлөвтэй тул 2021, 2022 онуудад үнийн төсөөллийг нэмэгдүүлэв. Төмрийн хүдрийн үнэ Блүүмберг, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын төсөөллийн дунджаар 2021 онд \$126/тонн, 2022 онд \$87/тоннд хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэх хүлээлттэй байна.

**Түүхий нефть:** Брент маркийн газрын тосны үнэ 2021 оны 1-р сард дунджаар 56 ам.доллар/баррель байсан бол 2-р сард дунджаар 66 ам.доллар/баррель хүрч нэмэгдлээ. Дэлхий дахинд КОВИД-19-ийн вакцинжуулалт үргэлжилж, АНУ-ын агуулахууд дахь газрын тосны нөөц буурсан болон ОПЕК+ нэгдэл үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн танах хүлээлт зэргийн нөлөөгөөр газрын тосны үнэ 2-р сард нэмэгдэв. Олон улсын эрчим хүчний байгууллагын тооцооллоор дэлхийн газрын тосны эрэлт 2023 оныг хүртэл цар тахлын өмнөх түвшиндээ хүрэхээргүй байгаа тул газрын тосны үнэ огцом нэмэгдэхээргүй байна. Ийнхүү газрын тосны үнэ Блүүмберг, EIU, Австралийн Нөөц эрчим хүчний байгууллагын төсөөллийн дунджаар 2021 онд \$54/баррель байсан бол 2022 онд \$56/баррельд хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна.


### IV.3 Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны 4 дүгээр улиралд 1,259 сая ам.доллар буюу ДНБ<sup>30</sup>-ий 9.6 хувьтай тэнцэх ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 1071 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт болов. Улмаар жилийн дүнгээр төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт сэргэж, импорт агшиж, орлогын дансны алдагдал буурснаар урсгал тэнцэл 165.4 сая ам.долларын ашигтай байв. ГШХО-ын орох урсгал өмнөх оны мөн үетэй харьцуулахад татарсан ч гадаад зээлийн ашиглалт нэмэгдэж, бусад хөрөнгө оруулалтын орох урсгал нэмэгдсэнээр санхүүгийн тэнцэл 1070 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөллөө.

#### Зураг IV.3.1

2020 оны 4-р улиралд урсгал болон санхүүгийн дансны ашиг төлбөрийн тэнцлийг ашигтай гарахад нөлөөлөв.




Эх сурвалж: Монголбанк

**Урсгал данс** сүүлийн 2 улирал дараалан ашигтай байв. Тайлант улиралд урсгал тэнцлийн ашиг 165.4 сая ам.доллар (ДНБ-ий 1.3%-)т хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1'132 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм. Экспортын орлого өмнөх оны мөн үеэс 756 сая ам.доллараар нэмэгдэж, харин эдийн засгийн идэвхжил саарсан үед импорт өмнөх оны мөн үеэс 163 сая ам.доллараар,

үйлчилгээний дансны алдагдал 157 сая ам.доллараар, орлогын дансны алдагдал 116 сая ам.доллараар тус тус агшсанаар урсгал тэнцэл ашигтай гарав. Урсгал тэнцлийн алдагдал 2019 онд ДНБ-ий 15.4 хувийг эзэлж байсан бол 2020 онд 4.4 хувьтай тэнцэх алдагдалтай байв (Зураг IV.3.3).

#### Зураг IV.3.2


Экспорт өсч, импорт бууран, үйлчилгээ болон орлогын дансны алдагдал багасав.



Эх сурвалж: Монголбанк

#### Зураг IV.3.3

Урсгал тэнцлийн алдагдал агшив.



Эх сурвалж: Монголбанк

**Барааны тэнцэл** 2020 оны 4-р улиралд 886.4 сая ам.долларын ашигтай байв. **Экспорт** 2020 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 756 сая ам.доллараар буюу 45.1 хувиар нэмэгдлээ (Хүснэгт IV.3.2). Тайлант улиралд экспорт өсөхөд алт болон зэсийн баяжмалын экспорт голлох нөлөөтэй байв.

<sup>30</sup> 4-н улирлын өссөн нэмэгдсэн ДНБ-ий дүн.

## Хүснэгт IV.3.2

Мөнгөжөөгүй алт, зэсийн баяжмалын экспорт нэмэгдсэн нь нийт экспорт өсөлтийг голлон тэтгэв.

|                         | 2019<br>IV   | 2020<br>IV   | Жилийн<br>өөрчлөлт | Өсөлтөд<br>эзлэх % |
|-------------------------|--------------|--------------|--------------------|--------------------|
| <b>Нийт экспорт</b>     | <b>1,674</b> | <b>2,429</b> | <b>45.1%</b>       | <b>45.1%</b>       |
| Мөнгөжөөгүй алт         | 74           | 622          | 738.5%             | 32.7%              |
| Зэсийн хүдэр, баяжмал   | 375          | 612          | 63.2%              | 14.2%              |
| Мөнгө                   | -            | 25           | -                  | 1.5%               |
| Ноолуур                 | 17           | 40           | 134.0%             | 1.4%               |
| Төмрийн хүдэр, баяжмал  | 154          | 176          | 14.4%              | 1.3%               |
| Чулуун нүүрс            | 640          | 648          | 1.3%               | 0.5%               |
| Цайрын хүдэр, баяжмал   | 44           | 43           | -1.0%              | 0.0%               |
| Жонш, лейцит, нефелинт  | 50           | 41           | -18.6%             | -0.6%              |
| Мах, махан бүтээгдэхүүн | 63           | 53           | -15.8%             | -0.6%              |
| Машин, тоног төхөөрөмж  | 32           | 13           | -59.7%             | -1.1%              |
| Боловсруулаагүй нефть   | 95           | 65           | -31.6%             | -1.8%              |
| Бусад <sup>31</sup>     | 131          | 93           | -36.6%             | -2.3%              |

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ харьцангуй өндөр түвшинд тогтвортой байсан тул Монголбанк худалдан авсан алт болон өмнөх 2 жилд мөнгөжүүлсэн алтны тодорхой хэсгээс тайлант улиралд 10.2 тонн алт экспортолсон нь нийт экспортод 32.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж өмнөх оны мөн үеэс 2.6 дахин нэмэгдсэнээс гадна зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнэ өндөр байсан нь зэсийн экспортын орлого нэмэгдэх шалтгаан боллоо. 2020 оны 3-р улиралд огцом буураад байсан ноолуурын экспорт 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 2.3 дахин нэмэгдэж, нийт экспортод 1.4 нэгж хувийн өсгөх нөлөө үзүүллээ. Төмрийн хүдрийн үнэ харьцангуй өндөр түвшинд тогтвортой байж, экспортын тээвэр хэвийн үргэлжилсэн нь экспортын орлого өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсөхөд нөлөөллөө. “Ногоон гарц” горим хэрэгжин, 10, 11-р саруудад нүүрсний экспорт өссөн хэдий ч 12-р сард БНХАУ-ын талаас нүүрсний импортоо бууруулснаар тайлант улиралд нүүрсний экспорт өмнөх оны түвшинд хадгалагдав.

**Импорт** 2020 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 163 сая ам.доллараар буюу 10.7 хувиар бага байв. 2020 оны 11-р сард КОВИД-19 дотоодод тархсаны улмаас хөл хорио чангарч, дотоод эрэлт болон эдийн засгийн идэвхжил огцом буурсан тул хэрэглээний импортоос бусад бүх импортын бүрэлдэхүүн хэсгүүд өмнөх оны мөн үеэс агшив. Ялангуяа, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 18.9 хувиар буурсан нь тайлант улиралд импортын агшилтын -8.2 нэгж хувийг бүрдүүллээ. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ бага түвшинд хадгалагдаж, нефтийн бүтээгдэхүүний импортын төлбөр буурлаа.

## Хүснэгт IV.3.3

Нефтийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт хурдтай буурав.

|                          | 2019<br>IV   | 2020<br>IV   | Жилийн<br>өөрчлөлт | Өсөлтөд<br>эзлэх % |
|--------------------------|--------------|--------------|--------------------|--------------------|
| <b>Нийт импорт</b>       | <b>1,529</b> | <b>1,366</b> | <b>-10.7%</b>      | <b>-10.7%</b>      |
| Хэрэглээний бүтээгдэхүүн | 400          | 433          | 8.1%               | 2.1%               |
| Үүнд: Түргэн эдэлгээт    | 238          | 249          | 4.5%               | 0.7%               |
| Удаан эдэлгээт           | 162          | 184          | 13.4%              | 1.4%               |
| Хөрөнгө оруулалтын бүт.н | 662          | 537          | -18.9%             | -8.2%              |
| Нефтийн бүтээгдэхүүн     | 308          | 234          | -24.1%             | -4.8%              |
| Үүнд: Дизель             | 162          | 128          | -21.0%             | -2.2%              |
| Бусад шатахуун           | 146          | 106          | -27.5%             | -2.6%              |
| Аж үйлдвэрлэлийн орц     | 158          | 151          | -4.0%              | -0.4%              |
| Бусад                    | 1            | 11           | 882%               | 0.7%               |

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк


**Үйлчилгээний дансны алдагдал** 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 157 сая ам.доллараар буюу 26.7 хувиар буурч -432 сая ам.долларт хүрэв. Дотоодод хөл хорио чангарч, эдийн засгийн идэвхжил саарсны улмаас тээвэр, аялал, бизнес, бусад үйлчилгээ гээд бүх төрлийн үйлчилгээний зардлууд багассан нь алдагдал буурахад нөлөөллөө. Харин тайлант улиралд манай улсын хил хаалттай хэвээр байж, аяллын үйлчилгээний орлого

<sup>31</sup> Бусад экспортын өөрчлөлтийг амьд малын экспорт болон бусад уул уурхайн экспортын бууралт тайлбарлаж байна.

буурсан нь үйлчилгээний дансны алдагдлыг өсгөх чиглэлд голлон нөлөөлөв.

#### Зураг IV.3.4


Үйлчилгээний дансны алдагдал 4-р улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад агшив.



**Орлогын дансны алдагдал** 2020 оны 4-р улиралд 480 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 30 сая ам.доллараар буюу 6.6 хувиар тэлэв. Үүнд хөрөнгө оруулалтын орлогын гарах урсгал өмнөх оны мөн үеэс 38.5 сая ам.доллараар буюу 7.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Тодруулбал, Оюу толгой компанийн ашигт ажиллагаа нэмэгдсэн голлох нөлөөгөөр дахин хөрөнгө оруулалтын орлогын гарах урсгал өмнөх оны мөн үеэс 52.7 сая ам.доллараар өсч 116.8 сая ам.долларт хүрэв. Мөн ногдол ашгийн орлогын цэвэр гарах урсгал 26.5 сая ам.доллараар нэмэгджээ.

#### Зураг IV.3.5


Орлогын дансны алдагдал тэлэв.



**Санхүүгийн дансны тэнцэл** 2020 оны 4-р улиралд 1070 сая ам.долларын ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 151.3 сая ам.доллараар буюу 12.4 хувиар буурсан үзүүлэлт болов. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 343.2 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалт 20.3 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөллөө. Харин бусад хөрөнгө оруулалтын дансны цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 206 сая ам.доллараар өссөн нь санхүүгийн дансанд эерэгээр нөлөөлөв.

#### Зураг IV.3.6

Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс бага байв.



Тайлант хугацаанд Оюу толгой болон бусад ААН-үүдийн ГШХО цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 458.2 сая ам.доллараар буюу 2.5 дахин буурч 296.0 сая ам.долларт хүрсэн бол ААН-үүдийн үндсэн төлбөр өмнөх оны мөн үеэс 27 орчим сая ам.доллараар буюу 48.4 хувиар өсч 82.5 сая ам.долларт хүрэв. Түүнчлэн, тайлант хугацаанд Оюу толгой компанийн ашигт ажиллагаа нэмэгдсэн голлох нөлөөгөөр орлогын дахин хөрөнгө оруулалт 52.7 сая ам.доллараар буюу 82 хувиар өсч 116.8 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байв.

Багцын хөрөнгө оруулалтын цэвэр гарах урсгал өмнөх оны мөн үеэс 20.3 сая ам.доллараар өсч, 50.4 сая ам.доллар болсон нь хувийн секторын ААН-үүдийн бондын


аккруэль хүүгийн зөрүүтэй холбоотой байна.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 206.4 сая ам.доллараар өсч, 691.8 сая ам.долларт хүрэв. Дээрх өөрчлөлтөд Засгийн газрын урт хугацаат гадаад зээлийн цэвэр орох урсгал өмнөх оны мөн үеэс 234 сая ам.доллараар буюу 80 хувиар өсч 526.4 сая ам.долларт хүрсэн, бусад секторын гадаад зээлийн цэвэр гарах урсгал өмнөх оны мөн үеэс 35.4 сая ам.доллараар буюу 40 хувиар буурч 52.5 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай байсан нь голлон нөлөөлөв.

**Гадаад валютын албан нөөц (ГВАН) 2020 оны эхнээс 185.6 сая ам.доллараар өсч, оны эцэст 4534.2 сая ам.долларт хүрэв.** Энэ нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 10.7 сарын хэрэгцээг хангах түвшин юм (Зураг IV.3.7). Төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай байсан бол нөгөө талдаа мөнгөжсөн алтны нөөцөөс алт экспортолсон нөлөөгөөр алтны нөөц 624 сая ам.доллараар буурч ийнхүү ГВАН-ийн өөрчлөлт өмнөх оноос 185.6 сая ам.доллараар өслөө. 2021 оны 2-р сарын эцэст ГВАН 4412.5 сая ам.доллар байна.

### Зураг IV.3.7

Гадаад валютын албан нөөц 10.7 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байна.



Эх сурвалж: Монголбанк

### Хүснэгт IV.3.1

#### Төлбөрийн тэнцлийн 2021 оны төсөөлөлд ашигласан таамаглалт нөхцөлүүд

| Өмнөх төсөөлөл (2021)                                                                                                                                                                                                                                                                                   | Одоогийн төсөөлөл (2021)                                                                                                                                                                                                                                                                              |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Экспорт</b>                                                                                                                                                                                                                                                                                          | <b>Төсөөлөл сайжирсан.</b>                                                                                                                                                                                                                                                                            |
| Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж нэмэгдэнэ. Нүүрсний экспорт 36 сая тонн хүрч өснө. Энэ онд алтны нөөцөөс зарахгүй. Монголбанк худалдан авсан алтаа бүгдийг цэвэршүүлж, экспортолно. <b>Үүнийн төсөөлөл:</b> Зэс, алтны үнэ ↑, газрын тосны үнэ тогтвортой, нүүрс, төмрийн хүдрийн үнэ ↓. | Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж нэмэгдэнэ. Нүүрсний экспорт 36 сая тонн хүрэх төсөөлөл хэвээр. Энэ онд алтны нөөцөөс зарахгүй. Монголбанк худалдан авсан алтаа бүгдийг цэвэршүүлж, экспортолно. <b>Үүнийн төсөөлөл:</b> ↑: Зэс, нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн үнэ ↑. Алтны үнэ ↓. |
| <b>Импорт</b>                                                                                                                                                                                                                                                                                           | <b>Төсөөлөл нэмэгдсэн.</b>                                                                                                                                                                                                                                                                            |
| Оюу толгойн ХО → ХО-ын бүтээгдэхүүний импорт өндөр хэвээр. Дотоодод халдвар тархсан → Эдийн засгийн идэвхжил саарах → хэрэглээний импорт алгуур өсөх, Нүүрсний олборлолт, экспорт ↑ → нефтийн бүтээгдэхүүний импорт ↑                                                                                   | Оюу толгойн ХО өмнөх төсөөлөлөөс ↓ → ХО-ын бүтээгдэхүүний импорт ↓. Дотоодод халдвар тархсан ч хөл хорионы дэлгэм суларч, Эдийн засгийн идэвхжил ↑ → хэрэглээний импорт ↑. Нүүрсний олборлолт, экспорт ↑, газрын тосны үнэ ↑ → нефтийн бүтээгдэхүүний импорт ↑                                        |
| <b>Үйлчилгээ</b>                                                                                                                                                                                                                                                                                        | <b>Өмнөх төсөөллийн орчимд</b>                                                                                                                                                                                                                                                                        |
| Ковид-19 → Улсын хил хаасан → аяллын орлого энэ онд орж ирэхгүй гэж үзэв. Нүүрсний экспорт ↑ → тээврийн зардал ↑. Хөл хорио → эдийн засгийн идэвхжил алгуур байх → бусад үйлчилгээний зардал ↓. ОТ-н ГШХО үргэлжлэх → тээвэр, бизнесийн үйлчилгээний зардал өмнөх оны түвшинд                           | Ковид-19 → Улсын хил хаасан → аяллын орлого энэ онд орж ирэхгүй гэж үзэв. Нүүрсний экспорт, импорт ↑ → тээврийн зардал ↑. Эдийн засгийн идэвхжил ↑ → бусад үйлчилгээний зардал ↑. ОТ-н ГШХО ↓ → тээвэр, бизнесийн үйлчилгээний зардал ↓                                                               |
| <b>ГШХО</b>                                                                                                                                                                                                                                                                                             | <b>Төсөөлөл муудсан.</b>                                                                                                                                                                                                                                                                              |
| Оюу толгойн ГШХО өмнөх оны түвшинтэй ойролцоо байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд санхүүжилт орж ирнэ. Ковид-19 → ОТ-оос бусад хувийн секторын гадаад шууд хөрөнгө оруулалт төдийлөн сэргэхгүй.                                                                       | Оюу толгойн ГШХО өмнөх төсөөлөлөөс 370 сая ам.доллараар буурахаар байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хүрээнд санхүүжилт орж ирнэ. Ковид-19 → ОТ-оос бусад хувийн секторын гадаад шууд хөрөнгө оруулалт төдийлөн сэргэхгүй.                                                 |
| <b>Багцын ХО</b>                                                                                                                                                                                                                                                                                        | <b>Төсөөлөл баг зэрэг сайжирсан.</b>                                                                                                                                                                                                                                                                  |
| МУ-ын Засгийн газар Мазаалай бондын үндсэн төлбөрийн үлдэгдэл 140 орчим сая ам.доллар эргэн төлнө.                                                                                                                                                                                                      | МУ-ын Засгийн газар Мазаалай бондын үндсэн төлбөрийн үлдэгдэл 140 орчим сая ам.доллар эргэн төлнө. МНК ОССК 2021 оны 2-р сард олон улсын хөрөнгийн зах дээр 250 сая ам.долларын бонд босгож, 2022 онд эргэн төлөх хуваарьтай Өзлүн бондын үндсэн төлбөрийн тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэв.       |
| <b>Бусад ХО</b>                                                                                                                                                                                                                                                                                         | <b>Төсөөлөл муудсан.</b>                                                                                                                                                                                                                                                                              |
| Донор санхүүжилтийн дүн өмнөх оноос буурах → Засгийн газрын гадаад санхүүжилт өмнөх оноос ↓, банкуудын урт хугацаат гадаад зээлийн ашиглалт өмнөх оны түвшинд байх төлөвлөгөөтэй.                                                                                                                       | Донор санхүүжилтийн дүн ↓, Засгийн газар, банк, хувийн секторын гадаад зээлийн ашиглалт өмнөх төсөөлөлөөс буурахаар байна.                                                                                                                                                                            |

Эх сурвалж: Монголбанк



МОНГОЛБАНК